



# ОРОН НУТГИЙН ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦ ДАХЬ ИРГЭДИЙН ОРОЛЦОО

## Судалгааны тайлан

*(АРХАНГАЙ, БУЛГАН, ХЭНТИЙ АЙМАГ )*

### **СУДАЛГААНЫ ЗӨВЛӨХ:**

Д. Бямбажав (МУБИС, Нийгмийн Ухааны тэнхим, багш судлаач)

С. Түмэндэлгэр (МУБИС, Нийгмийн Ухааны тэнхим, багш судлаач)

### **ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН:**

Г.Цэцгээ (ТАН төсөл, Мерси Кор Монгол ОУБ)

Ж.Шүрэнцэцэг (ТАН төсөл, Мерси Кор Монгол ОУБ)

УЛААНБААТАР ХОТ  
2007 ОН

*Энэхүү тайланг хэсэгчлэн болон бүтнээр нь хэвлэхийг хүсвэл Мерси Кор ОУБ-ын ТАН төслийн хаягаар хандаж зохих зөвшөөрөл авах буюу иш татсан тохиолдолд байгууллага болон энэхүү тайлангийн нэрийг заавал дурьдана.*

*Энэхүү хэвлэлд тусгасан мэдээлэл нь АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг болон АНУ-ын Засгийн Газарт хамаарахгүй болно.*

---

Улаанбаатар хот, Мерси Кор ТАН төсөл  
Энхтайвны өргөн чөлөө - 24  
Баянзүрх дүүрэг  
Утас: (976-11)-460905  
Факс: (976-11)-461048  
И-мэйл: [tan@mercycorps.org.mn](mailto:tan@mercycorps.org.mn)  
Вэб хуудас: [www.mercycorps.org.mn](http://www.mercycorps.org.mn)

## ГАРЧИГ

I. ӨМНӨХҮГ.....	7
II. ТОВЧ ХУРААНГУЙ.....	9
III. УДИРТГАЛ.....	21
IV. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ.....	24
V. МОНГОЛ УЛСЫН НУТГИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО.....	27
VI. ОДОО ХЭРЭГЛЭГДЭЖ БУЙ МЕХАНИЗМУУД БА ОРОН НУТГИЙН ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦ ДАХЬ ИРГЭДИЙН ОРОЛЦОО.....	29
1. Багийн түвшин дэх иргэдийн оролцоо.....	29
2. Аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын түвшин дэх иргэдийн оролцоо.....	39
3. Сум, аймгийн засаг дарга нар болон иргэдийн хоорондын харилцаа.....	49
VII. ОРОН НУТАГ ДАХЬ ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУД.....	56
VIII. ДҮГНЭЛТ.....	61
IX. ЗӨВЛӨМЖҮҮД.....	65
ХАВСРАЛТ 1-Анкетын судалгааны асуулт.....	69
ХАВСРАЛТ 2-Аймгуудаар ялгасан хүснэгтүүд.....	82
ХАВСРАЛТ 3 “Шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн оролцоо” сэдэвт судалгааны тайлангийн хурлын тэмдэглэл (Архангай аймаг, Эрдэнэбулган сум).....	85
ХАВСРАЛТ 4 “Шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн оролцоо” сэдэвт судалгааны тайлангийн хурлын тэмдэглэл (Булган аймаг, Булган сум).....	88
ХАВСРАЛТ 5 “Шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн оролцоо” сэдэвт судалгааны тайлангийн хурлын тэмдэглэл (Хэнтий аймаг, Хэрлэн сум).....	91



## СУДАЛГААНЫ БАГ

1. Э.Оюунчимэг *Архангай аймгийн Мэдээлэл Гэгээрлийн Ай-И-Си төвийн менежер, ТАН төслийн зохицуулагч*
2. Б.Ариунбат *Архангай аймгийн Оюутны Холбоо*
3. Б.Энхжаргал *Архангай аймгийн Залуучуудын Холбоо*
4. Б.Ариунаа *Архангай аймгийн ЛЭОС-ийн Залуучуудын Клуб*
5. Д.Батдэлгэр *Архангай аймгийн Залуу Лидер Клуб*
6. Б.Жаргалсайхан *Архангай аймгийн Залуучуудын Холбоо*
7. Д.Оюунбилэг *Булган аймгийн НДЭХ-ний зохицуулагч, ТАН төслийн зохицуулагч*
8. Д.Ганболд *Булган аймгийн «Булган Уран» Хоршоо*
9. Д.Даваасүрэн *Булган аймгийн Хуульч Эмэгтэйчүүдийн Холбоо*
10. Ш.Даариймаа *Булган аймгийн Хүний Эрхийн Зөвлөл*
11. Д.Чимгээ *Булган аймгийн ЛЭОС*
12. Г.Наранцэцэг *Булган аймгийн Хуульч эмэгтэйчүүдийн холбоо*
13. З.Бат-Эрдэнэ *Хэнтий аймгийн НДЭХ-ний зохицуулагч, ТАН төслийн зохицуулагч*
14. З.Отгонбаяр *Хэнтий аймгийн “Хан хэнтий хамтын хүч” ТББ*
15. Б.Оюунцэцэг *Хэнтий аймгийн Хөгжлийн Бэрхшээлтэй Эцэг Эхийн Холбоо*
16. Д.Оюун *Хэнтий аймгийн “Эмэгтэйчүүдийн зөвлөл”*
17. С.Цэцэгмаа *Хэнтий аймгийн Ахмадын Хороо*
18. Ц.Сүнжидмаа *Хэнтий аймгийн НДЭХ*



## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ:

ТАН	<i>Сургалт, Нөлөөлөл ба Хамтын ажиллагааны сүлжээ төсөл</i>
ИНБ	<i>Иргэний Нийгмийн Байгууллага</i>
АШСТО	<i>Ардчиллыг Шинээр болон Сэргээн Тогтоосон Орнууд</i>
ЗДТГ	<i>Засаг Даргын Тамгын Газар</i>
ЗД	<i>Засаг Дарга</i>
ИНХ	<i>Иргэдийн Нийтийн Хурал</i>
ИТХ	<i>Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал</i>
МУЗЗНДНХ	<i>Монгол Улсын Засаг Захиргаа Нутаг Дэвсгэрийн Нэгжийн тухай хууль</i>
ХХҮХ	<i>Хөдөлмөр Халамж Үйлчилгээний Хэлтэс</i>
НБЗХ	<i>Нийгмийн Бодлого Зохицуулалтын хэлтэс</i>
ЭМГ	<i>Эрцл Мэндийн Газар</i>
БСГ	<i>Боловсрол Соёлын Газар</i>
МХГ	<i>Мэргэжлийн Хяналтын Газар</i>
ТББ	<i>Төрийн бус байгууллага</i>
ЛЭОС	<i>Либерал Эмэгтэйчүүдийн Оюуны Сан</i>
НДЭХ	<i>Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд Хөдөлгөөн</i>
ХЭХ	<i>Хуульч Эмэгтэйчүүдийн Холбоо</i>
ЗХ	<i>Залуучуудын Холбоо</i>
ОХ	<i>Оюутны Холбоо</i>
МСҮТ	<i>Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн Төв</i>
ЭЗ	<i>Эмэгтэйчүүдийн Зөвлөл</i>
ҮЭХ	<i>Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо</i>
АОЭХ	<i>Ажил Олгогч Эздийн Холбоо</i>

## ХҮСНЭГТ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ:

- Бүдүүвч 1.** Монгол улсын нутгийн удирдлагын тогтолцоо
- Хүснэгт 1.** Багийн нийтийн хурлын оролцоо (эрхэлж буй ажлаар)
- Хүснэгт 2.** Мэдээлэл байхгүй учраас багийн хуралд оролцдоггүй
- Хүснэгт 3.** Багийн нийтийн хурлын талаархи мэдээлэл ба иргэдийн оролцоо
- Хүснэгт 4.** Багийн ИНХ, ЗД-ын талаар иргэд хэр мэдээлэлтэй байдаг вэ?
- Хүснэгт 5.** Багийн удирдлагын талаархи иргэдийн мэдээлэл (оршин суугаа газраар)
- Хүснэгт 6.** Сум, аймгийн ИТХ-ын талаар иргэд хэр мэдээлэлтэй байдаг вэ?
- Хүснэгт 7.** Орон нутгийн удирдлагын талаархи мэдээллийг олж авдаг сувгууд
- Хүснэгт 8.** Сум, аймгийн ЗД нар шийдвэр гаргахдаа иргэдийн санал бодлыг тусгах байдал



- Хүснэгт 9.** Нутгийн удирдлагын байгууллагууд юуны талаар тайлагнадаг вэ?
- Хүснэгт 10.** Танай орон нутагт идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг ямар ТББ байдаг вэ?
- Хүснэгт 11.** Уламжлалт ТББ-уудыг та мэдэх үү (насны ангиллаар)
- Хүснэгт 12.** ТББ-ын талаар мэдэхгүй гэж хариулсныг аймаг тус бүрээр
- Хүснэгт 13.** Орон нутгийн ТББ-уудын үйл ажиллагаан дахь иргэдийн оролцоо
- Хүснэгт 14.** Орон нутгийн ТББ-уудын үйл ажиллагаан дахь иргэдийн оролцоо (огт оролцдоггүй иргэдийн эзлэх хувь, насны ангиллаар)
- Хүснэгт 15.** Иргэдийн хамтран ажилладаг хэлбэрүүд
- 
- График 1.** Анкетын судалгаанд оролцогчид, насны байдал
- График 2.** Анкетын судалгаанд оролцогчид, аймгаар
- График 3.** Анкетын судалгаанд оролцогчид, байршлаар
- График 4.** Анкетын судалгаанд оролцогчид, боловсролын түвшингээр
- График 5.** Багийн иргэдийн нийтийн хурал дахь иргэдийн оролцоо
- График 6.** Багийн хуралд оролцдог бол жилд хэдэн удаа оролцдог вэ?
- График 7.** Иргэдийн багийн хуралд оролцдоггүйн шалтгаан
- График 8.** Та хурлын төлөөлөгчтэй хэр тогтмол уулздаг вэ?
- График 9.** Та дараах байгууллагуудад өргөдөл, гомдол, саналаа илэрхийлж байсан уу?
- График 10.** Та өөрийн өргөдөл, гомдол, саналаа ихэвчлэн хэнд хандаж гаргадаг вэ?
- График 11.** ИТХ шийдвэр гаргахдаа иргэдийн саналыг тусгадаг уу?
- График 12.** Иргэдийн ИТХ-д оролцох боломжууд
- График 13.** Сум, аймгийн ЭД нарын талаар иргэд хэр зэрэг мэдээлэлтэй вэ?
- График 14.** Иргэдийн санал бодлыг асууж, зөвлөлдөх арга хэлбэрүүд
- График 15.** Сум, аймгийн ЭД нарын тайлангаа хэлэлцүүлдэг байдал, аймгаар



## I. ӨМНӨХ ҮГ

Сургалт, Нөлөөлөл ба Хамтын Ажиллагааны Сүлжээ (ТАН) төсөл нь “Орон нутгийн шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн оролцоо” судалгааг Архангай, Булган, Хэнтий аймгуудад 2006 оны 6-8 сард явуулсан. АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн санхүүжүүлтээр Мерси Кор Монгол байгууллагын хэрэгжүүлж байгаа ТАН төсөл нь Монголын хөдөө нутагт үр нөлөөтэй, хамтран ажиллах чадвартай, мэргэшсэн иргэний нийгмийн байгууллагуудыг бэхжүүлэх зорилготой, таван жилийн хугацаанд хэрэгжих төсөл юм. 2004-2006 онд ТАН төсөл Өвөрхангай, Дундговь аймгуудад, 2005 оноос эхлэн Архангай, Булган, Хэнтий аймгуудад үйл ажиллагаагаа явуулж байна. ТАН төсөл нь иргэдийн оролцоог нэмэгдүүлэх талаар иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ-ууд) болон орон нутгийн төр захиргааны байгууллагуудтай хамтран ажилладаг. ТАН төсөл нь хөдөө орон нутаг дахь иргэний нийгмийн байгууллагууд, сүлжээг чадваржуулан бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг.

Монголын ИНБ-ууд өнгөрсөн хугацаанд иргэдийн оролцооны талаар судалгаа хийж байсангүй. Ийм учраас ТАН төсөл орон нутгийн шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн оролцооны талаар судалгаа явуулах санаачлага гарган, орон нутгийн ИНБ-ууд, сайн дурын ажилтнуудад оролцооны судалгааны арга зүйн талаар сургалт явуулснаар мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх чадвартай болгосон. Уг судалгааны зорилго нь аймаг, сум, багийн засаг дарга болон иргэдийн төлөөлөгчдийн хурлын (ИТХ) түвшинд шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн оролцоог хангах ямар механизмууд байгаа, хэрхэн хэрэгжиж буйг тодорхойлоход чиглэсэн. Ялангуяа хууль, дүрэм журмуудад уг механизмыг хэрхэн тусгасан, түүний бодит амьдрал дахь хэрэгжилт ямар байгаа, иргэд хэрхэн ашигладаг, иргэдийн оролцоог илүү нэмэгдүүлэхэд тулгарч байгаа бэрхшээлүүд юу болохыг тодруулахыг зорьсон. Судалгаанаас гарах зөвлөмжүүд нь одоо байгаа механизмыг сайжруулах, иргэдийн оролцоог хангахад чиглэсэн оролцооны ямар механизм байж болохыг тусгасан болно.



ТАН төсөл Монгол улсын боловсролын их сургуулийн мэргэжлийн судлаачидтай хамтран судалгааны ажлын нарийвчилсан төлөвлөгөөг гаргаж, орон нутгийн ИНБ-уудаас 18 хүнийг судалгааны тоо баримт цуглуулах, судалгааны арга зүйн сургалтад хамруулсан. Судалгааны баг нь иргэдийн мэдлэг, хандлага, иргэдийн оролцооны механизм, түүнийг орон нутгийн шийдвэр гаргах түвшинд хэрхэн хэрэгжүүлж байгааг судалсан.

Судалгааг баримт бичигт дүн шинжилгээ хийх, ганцаарчилсан ба бүлгийн ярилцлагын аргаар явуулсан. Судалгаа нь 3 аймгийн 480 хүнийг анкетын судалгаанд хамруулсан байна. Судалгааны баг нь судалгаагаар гарч ирсэн асуудлууд, зөвлөмжийг орон нутгийн төр захиргаа, бусад байгууллагуудад танилцуулж тэдний саналыг тусгах болно. Цаашид орон нутгийн шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд орон нутгийн төр захиргааны байгууллага, ИНБ-уудтай хамтран үйл ажиллагаа явуулж, техникийн туслалцаа үзүүлэх болно.



## II. ТОВЧ ХУРААНГУЙ

*Орон нутгийн удирдлагын бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн үр нөлөө бүхий оролцоо хангагдаж чадахгүй байна. Нутгийн удирдлагын байгууллагууд, ялангуяа аймаг, сумдын ИТХ, Засаг даргын түвшний бодлогын үйл явцад иргэдийн оролцоо маш сул байгаа нь иргэдийн оролцоог хангахад чиглэсэн эрх зүйн зохицуулалт, удирдлагын туршилага байхгүй, иргэдэд хүрч буй мэдээлэл болон мэдээлэл олж авах эрх хязгаарлагдмал, үүнээс үндэлтэй иргэдэд оролцоог үл мэдэх, үл ойшоох хандлага бий болсонтой холбоотой байна. Орон нутаг дахь Иргэний нийгмийн байгууллагуудын чадавхи, санхүүгийн байдал сул, оролцоог хангах механизм байхгүйгээс гадна орон нутгийн удирдлага тэднийг шийдвэр гаргах үйл явцад оролцуулах сонирхолгүй байдаг байна. Уг асуудал нь төрийн удирдлагын төвлөрөл, орон нутгийн нийгэм, эдийн засаг, соёлын зэрэг олон хүчин зүйлстэй холбоотой хэдий ч судалгааны дүнд үндэслэн орон нутагт иргэдийн оролцоог нэмэгдүүлэх бодлогын зөвлөмжийг санал болгож байна.*

### УДИРТГАЛ

Төрийн удирдлагын ардчилсан зарчмыг хэрэгжүүлж буй үед орон нутгийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэдийг оролцуулах эсэх тухайд тайлбар хийх нь илүүц бөгөөд харин оролцоог хэрхэн хангаж, үр нөлөөг нэмэгдүүлэх тухайд нухацтай хандах ёстой. Төрийн удирдлагын ардчилсан байх зарчим нь маш энгийн хоёр хэм хэмжээгээр хэрэгжиж байдаг. Нэгдүгээрт, төрийн удирдлага бол асуудлыг шийдэх боломжит хувилбаруудаас хамгийн зохистойг нь ингэхдээ тухайн бодлого шийдвэрт эрх ашиг сонирхол хөндөгдөж буй талуудын санаа бодлыг сонссоны үндсэн дээр сонгох явдал байдаг. Хоёрдугаарт эрх ашиг хөндөгдөж буй талуудыг сонсох, байр суурийг харгалзах шилдэг арга бол тэднийг бодлогын үйл явцад оролцуулах явдал юм.



Шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангах нь ядуурлыг бууруулах, төрийн үйлчилгээг сайжруулах, төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, хөгжлийн бусад санаачлагуудыг амжилттай хэрэгжүүлэх маш чухал хөшүүрэг болохыг талууд зөвшөөрдөг. Гэвч оролцоо яагаад сул байна вэ?

### **НУТГИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО БА ИРГЭНИЙ ОРОЛЦОО**

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан зохион байгуулахаар хуулинд заасан байдаг.

Нутгийн өөрөө удирдах байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (ИТХ), баг, хороонд иргэдийн Нийтийн хурал (ИНХ), тухайн Хурлын хуралдааны чөлөө цагт түүний Тэргүүлэгчид байдаг.

Хэдийгээр эрх мэдэл төвд төвлөрч, орон нутгийн бие даасан байдал алдагдан, нутгийн удирдлагын байгууллагуудын эрх хэмжээ тун хязгаарлагдмал болсоныг хүлээн зөвшөөрч буй ч нутгийн удирдлагын байгууллагуудын эрх мэдлийн өнөөгийн байдлаас Аймгийн засаг дарга, ИТХ, Сумын засаг дарга, ИТХ, Багийн засаг дарга, хамгийн эцэст ИНХ гэсэн эрх мэдлийн шатлал ажиглагдаж байгаа. Иргэдийн оролцооны талаас авч үзвэл үүний эсрэг буюу Багийн ИНХ-д иргэдийн оролцоо харьцангуй дундаж боловч удирдлагын түвшин өгсөх тусам оролцоо буурч байна.

### **БАГИЙН ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРАЛ ДАХЬ ИРГЭДИЙН ОРОЛЦОО**

Хэдийгээр ИНХ-д хуулиар олгосон эрх хэмжээ нь тун хязгаарлагдмал боловч ИНХ нь харьяа багийн тулгамдсан асуудлыг иргэд өөрсдөө оролцон хэлэлцэх, багийн даргад үүрэг даалгавар өгөх, дээд шатны хурал, засаг даргад саналаа уламжлах боломжтой иргэний шууд оролцооны байгууллага юм. Багуудын хувьд жилд хэдэн удаа хуралддаг нь баг бүрт янз бүр байна. Зарим баг жилд 4-5 удаа хурал зохион байгуулдаг бол зарим баг ялангуяа аймгийн төвүүдийн баг 1-2-аас төдийлэн хэтэрдэггүй байна. Аймаг, сумын төвийн хувьд багийн ИНХ-ын ирц ихэнх тохиолдолд хангалтгүй, заримдаа ирц бүрдэхгүй (бүр хүн цуглахгүй) байх явдал нийтлэг байдаг бол харин хөдөөгийн багуудын хувьд ирц харьцангуй сайн байна.

Судалгаанд оролцогчдын 37.6 хувь нь багийнхаа хуралд огт оролцдоггүй гэж хариулсан байна. Харин 17.5 хувь тогтмол, 44.8 хувь нь хааяа оролцдог байна. Хуралд хамгийн идэвхтэй, тогтмол оролцдог иргэд бол 45-аас дээш насны иргэд байна. Судалгаанд оролцсон дээрх иргэдийн 74.8 хувь багийн хуралд оролцдог гэж хариулжээ.

Багийн иргэдийн хурал болдог үгүйг мэдэхгүй Ахмадуудын л хурал болдог байх.

*(Иргэдтэй хийсэн ярилцлагаас)*

Иргэдийн багийн ИНХ-д оролцох сонирхол, түүнээс хүлээх хүлээлт маш доогуур байна. Хуралд огт оролцдоггүй иргэдийн давхардсан байдлаар 39.3 хувь нь оролцлоо гээд юу ч өөрчлөгдөхгүй гэж хариулсаны сацуу 20 хувь нь сонирхол байдаггүй, 13.1 нь оролцоод ач холбогдолгүй гэж боддог гэжээ. Энэ нь нэг талаас багийн хурлын эрх хэмжээ тун хязгаарлагдмал, багт өөрийн төсөв хөрөнгө санхүүгийн эрх мэдэл огт үгүй байдагтай, нөгөө талаас иргэдийн хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлууд нь дээд шатны байгууллагад уламжлагдах боловч ихэнхдээ тодорхой үр дүнгүй замхардагтай холбоотой байна. Хэдийгээр эрх хэмжээ хязгаарлагдмал боловч багийн хурал бол иргэд олон асуудлыг хоорондоо хэлэлцэх, үзэл бодлоо илэрхийлэх, хамтран ажиллах, бие биенээ дэмжин туслах боломжтой газар юм. Гэвч ихэнхдээ дээд шатны төрийн байгууллагууд, үйлчилгээний байгууллагууд тухайлбал хүний эмч, малын эмч, цагдаа гэх мэтийн үйл ажиллагаа, тайланг танилцуулсан, иргэдийн үүргийн биелэлт ялангуяа татвар төлөлтийг байнга сануулсан, цөөн хэдэн тогтмол үг хэлдэг иргэд, ихэнх нь сонсогчийн хувиар оролцдог хурал болдог байна.

Хамгийн гол нь багийн хурлаар үр дүнтэй юм шийдэж чадахгүй хог нохой татвар гоожин нэхсээр байгаад залхаагаад очихгүй болсон юм шиг санагддаг. Уг нь бол орон нутгийнхаа сайн сайхны төлөө санаа бодлоо уралдуулж үгээ хэлэх ганц боломжтой газар чинь энэ. Бусад сум аймгийн хуралд бол иргэн санаа бодлоо илэрхийлнэ гэвэл бүтэхгүй ...

*(Иргэдтэй хийсэн ярилцлагаас)*

ИНХ-д оролцдоггүй иргэдийн 39.3 хувь нь мэдээлэл байхгүй учраас оролцож чаддаггүй гэжээ. Хачирхалтай нь аймгийн төвд амьдарч буй иргэд хөдөөний иргэдээс илүүтэйгээр ийм хариулт өгчээ. Хувийн секторт ажиллагсдын хувьд хуралд оролцож чаддаггүйгээ мэдээлэлгүй байдагтай холбон авч үзэх нь нийтлэг байв. Төрийн буюу төсвийн байгууллагын ажиллагсдын хувьд нутгийн удирдлагын байгууллагуудын талаархи мэдээлэл сайтай байгаа бөгөөд мөн багийн оролцоо нь ч өндөр байна. Энэ нь мэдээлэл түгээлт нутгийн удирдлагын байгууллагын өөрийн хүрээнээс цааш гарч чадахгүй байгааг илтгэнэ.

Судалгаанд оролцогчдын тал хувь нь «бусад хүмүүсийн ярианаас» мэдээлэл олж авч байгаа нь ам дамжсан яриа нутгийн удирдлагын талаар мэдээлэл дамжуулах нэгэн суваг болж байгааг харуулна. Харамсалтай нь ам дамжсан ярианаас үнэн мэдээлэл олж авах магадлал тун бага байдгийг судлаачид нотолсон байдаг.

ИНХ-ын талаархи иргэдийн мэдлэг боловсрол дутмаг байгаа нь тэдгээрийн оролцоонд нөлөөлж байна. Иргэд ИНХ-ын хууль ёсны эрх мэдлийн талаар төдийлэн мэдэхгүй байна. ТАН хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэний боловсрол олгох төсөл хэрэгжсэн багуудын ИНХ дахь иргэдийн ирц сайжирч, оролцооны хэлбэр, агуулга баяжиж байгаа нь иргэдтэй хийсэн бүлгийн ярилцлагаас ажиглагдаж байлаа. Иргэдийн дунд ИНХ-д оролцох ач холбогдол, зорилгыг зөвөөр ухаарсан ойлголт, хандлага, цаашлаад зан үйл бий болоогүй цагт ИНХ одоогийн байдлаасаа өөрчлөгдөх боломжгүй юм. Иймээс иргэдийн шийдвэр гаргах явц дахь оролцоог нэмэгдүүлэхийн тулд иргэдийн иргэний боловсролд чанарын ахиц дэвшил гаргахад анхаарах хэрэгтэй байна.

### **ИТХ-ИРГЭНИЙ ТӨЛӨӨЛӨЛ, ОРОЛЦООГ ХАНГАЖ БАЙНА УУ?**

Нэгэнт ИТХ нь төлөөллийн байгууллага тул иргэдийн оролцооны үндсэн суваг нь өөрийн харьяа нутаг дэвсгэрээс сонгогдсон төлөөлөгч болох учиртай. Нөгөө талаас ИТХ-ын хуралдаан, үйл ажиллагаа нь иргэдэд ил тод, нээлттэй байх нь оролцооны чухал нөхцөл юм. ИТХ-ын хурлын төлөөлөгч, Тэргүүлэгчид, тухайн нэгжийн Засаг дарга Хуралд хэлэлцүүлэхээр асуудал санаачлан оруулах эрхтэй бөгөөд төр, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж, тухайн шатны Хуралд, сум, дүүрэг, баг, хорооны Хурал зохих дээд шатны Хуралд асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно. Өөрөөр хэлбэл иргэд ИТХ-д асуудал оруулахыг хүсвэл дээрх эрх бүхий субъектуудээр дамжуулах шаардлагатай, төлөөлөгчид нь иргэдийн сонирхолыг нэгтгэж илэрхийлэх эрхтэй гэсэн үг.

ИТХ-ын хуралд иргэдийг оролцуулах талаар аймгийн хурлын дэгд дараах байдлаар тусгажээ. Булган аймгийн ИТХ-ын дэгийн 7-р зүйл, Хэнтий аймгийн ИТХ-ын дэгийн 2.9-д тухайн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын гишүүд, төр, нам, аж ахуй, хоршоолол, олон нийтийн байгууллагын ажилтан, хэвлэл мэдээллийн албаны хүмүүс, иргэдийг урилгаар оролцуулах асуудлыг хурлын тэргүүлэгчдээс зохион байгуулж болно. Урилгаар оролцогсод нь хуралдааны дотоод журам, дэгийг биелүүлэх үүрэгтэй гэж заажээ. Харин Архангай аймгийн хурлын дэгд иргэдийг оролцуулах талаарх ямар нэгэн зүйл заалт алга байна.

Сумдын тухайд мөн л 9 сумаас зөвхөн Булган аймгийн Булган сумын ИТХ-ын хуралдааны дэгд тухайн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдох албан тушаалтан болон иргэдийг урилгаар оролцуулах асуудлыг хурлын тэргүүлэгчид шийдвэрлэнэ гэж заажээ. Иргэдийг урилгаар оролцуулах нь иргэний оролцоог жинхэнэ утгаар хангаж буй хэрэг биш юм. Учир нь хурлын тэргүүлэгчид болон даргын сонирхол, үзэмжээр сонголт хийгдэж ирсэн бөгөөд жирийн иргэн өөрийн хүсэлтээр оролцох боломжгүй байдаг. Урилгаар оролцох гэдэг

нь санал хэлэх эрхгүйгээр ажиглагчийн байр сууриар л орж байгаа хэрэг юм. Энэ тохиолдолд иргэдийн хуралд ажиглагчаар оролцох хүрээг өргөжүүлж урилгаар бус харин иргэний хүсэлтийг харгалзан оролцуулж байх нь ардчиллын зарчимд нийцтэй. ИТХ-ын хуралдаан зарчмын хувьд нээлттэй явагдах ёстой ч түүнийг урилгаар оролцуулах гэдэг ойлголтоор хязгаарлаж байгаа нь ажиглагдаж байна. Иргэний саналын эрхгүй ч оролцох эрхээ эдлэх нөхцөлийг бүрдүүлж оролцоог өргөжүүлэх шаардлагатай байна.

ИТХ-ын хуралдаан зарчмын хувьд нээлттэй явагдах ёстой ч түүнийг урилгаар оролцуулах гэдэг ойлголтоор хязгаарлаж байгаа нь ажиглагдаж байна.

Сумын ИТХ иргэдтэйгээ 2 удаа нийлж хуралдсан. Уг хурлаар сумын ард иргэдээс байгаль хамгаалах талаар, хуурай хог хаягдлаас салах талаар нилээд ярьсан. Овоо ч хэрэгжсэн. Ингээд хамтраад ажиллаад байвал үр дүн нь уг нь сайн гаргах юм байна гэж бодогдсон.

*(Архангай, Малчидтай хийсэн ярилцлагаас)*


Эрх хэмжээний хүрээнд баримт бичгийн төслийг иргэдэд сурталчилж төдний саналыг өргөнөөр авах зорилгоор хурал цуглаан зохион байгуулах, хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төслийг орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтээр хэлэлцүүлж болно гэсэн заалт Булган аймгийн ИТХ-ын дэгд байгаа нь иргэний оролцоог хангахад чиглэсэн сайн туршага болохуйц зохицуулалт боловч үр дүн төдийлэн ажиглагдсангүй. Энэхүү эрх олгосон зохицуулалтыг үүрэг ногдуулсан болгох буюу орон нутгийн төсөв, нийгэм, эдийн засгийн томоохон хөтөлбөр, тулгамдсан нийтлэг асуудал зэргийг боловсруулж шийдэхдээ иргэдийн саналыг тусгах зорилгоор Нээлттэй сонголт (хэлэлцүүлэг) зохион байгуулах шаардлагыг дэгд тусгах нь тухайн шийдвэр гаргагчийн сонирхлоос үл хамааран хэвших нөхцөл бүрдэх юм. Орон нутгийн удирдлагад Нээлттэй сонголт хийх туршлага нь зарим сумдад нэг бус хэрэгжиж байсны сацуу УИХ-иар хууль хэлэлцэх үйл явцад хэрэгжиж эхлээд байгаа.

Иргэдийн төлөөлөгч бол орон нутгийн иргэдийн төлөөлөн болон сонгогдсон, иргэдийн эрх ашиг, хэрэгцээ, саналыг судлан хурлаар шийдүүлэх эрх үүрэг бүхий төрийн түшээ билээ. Төлөөлөгч нь хурлын эрх хэмжээний асуудал хэлэлцэхэд таслах эрхтэй оролцох, хуралд тодорхой асуудал хэлэлцүүлэхээр санаачлах, хурлаас байгуулсан байгууллага, сонгосон буюу томилсон албан тушаалтны илтгэл, сонголт хэлэлцүүлэх санал гаргах; хууль тогтоомж, хурлын шийдвэрийг иргэдэд тайлбарлан таниулах бүрэн эрх эдэлдэг.



Гэвч төлөөлөгчид иргэдтэй ойртож ажиллах, тэдний санаа бодлыг сонсох, бодлого шийдвэрт тусгахыг эрмэлзэх байдал тун хангалтгүй байна.

Судалгаанд оролцогчдын 20 орчим хувь нь өөрийн тойргоос сонгогдсон сумын ИТХ-ын төлөөлөгчөө, 3/1 орчим нь (хамгийн бага үзүүлэлт) өөрийн тойргоос сонгогдсон аймгийн ИТХ-н төлөөлөгчөө танихгүй байв. Мөн иргэдийн олонхи нь аймаг, сумын хурлын төлөөлөгчидтэй огт уулзалдаж ярилцдаггүй гэж хариулсан байна. Ялангуяа аймгийн хурлын төлөөлөгчидтэй иргэдийн 29.7 хувь нь уулзаж байсан байна. Нэгэнт өөрсдийнхөө сонгосон төлөөлөгчтэйгээ уулзаж санал хүсэлтээ илэрхийлдэггүй учраас иргэдийн санаа бодол, хэрэгцээ хурлаар хөндөгдөн яригддаг эсэх нь эргэлзээтэй. Иргэдийн олонх нь хурлын шийдвэрт иргэдийн санаа бодол тусдаггүй гэж үзжээ.



Хэдийгээр 2 жилийн өмнө буюу 2004 онд орон нутгийн ээлжит сонгууль болсон ч иргэдийн багагүй хувь нь өөрийн орон нутгаас буюу тойргоос сонгогдсон аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчөө танихгүй гэсэн нь төлөөлөгчид иргэдтэй ойртож ажиллахгүй, тэднийг жинхэнэ утгаар төлөөлж байгаа эсэхэд эргэлзэхэд хүргэж байна.

Шийдвэр гаргах түвшин дэх иргэдийн оролцоо болон ИТХ-ын төлөөлөгчидтэй ажиллах талын мэдлэг иргэдэд тун тааруу байна. Иргэд ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэх асуудлын санал гаргах, ИТХ-аас мэдээлэл авах эрхтэй болохоо мэдэхгүй байна. Мөн түүнчлэн ИНХ-ын хуралдаанд иргэд ажиглах үүрэгтэй оролцож болох, ТББ-ууд уригдаж оролцож болно гэдгийг судалгаанд оролцсон иргэдийн ихэнх нь мэдэхгүй байна. Иргэдийн 27.5 хувь хэрхэн оролцох талаарх мэдээлэл, мэдлэг дутмаг учраас ИТХ-д хандаж байгаагүй гэсэн байна. Мөн иргэдийн 50-60 хувь нь ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэх асуудлын санал гаргах, хэлэлцэх асуудлын талаар мэдээлэл авах арга зам, урилгаар оролцох тухайд ямар ч ойлголтгүй байна.

## ЗАСАГ ДАРГА-ИРГЭДИЙН ХАРИЛЦАА

Засаг дарга нь төрийн төвлөрсөн удирдлагыг орон нутагт хэрэгжүүлэгч гол албан тушаалтан билээ. Засаг даргын шийдвэр гаргах үйл явцад иргэд оролцох, нөлөөлөх явдлыг иргэдийн мэдээлэл авах боломж, засаг дарга шийдвэр гаргахаас өмнө (ялангуяа харьяа иргэд, орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт, нийтлэг асуудлын талаар) иргэдтэй зөвлөлдөх, санаа бодлыг судлах, хийсэн ажлаа иргэдэд тайлагнаж, хэлэлцүүлэх, удирдлагын ил тод байдлыг хангаж буйгаар тодорхойлж үзэх боломжтой.

Нутгийн захиргааны байгууллагын хувьд Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн дагуу төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдлыг ханган, төр иргэдийн холбоог сайжруулах зорилтыг аймгийн засаг дарга нар 2004-2006 үйл ажиллагааны хөтөлбөртөө тусгажээ. Үүнд аймгийн төр, захиргааны байгууллагын удирдлага орон нутгийн хэвлэл, радио телевиз, мэдээллийн утсаар дамжуулан тулгамдсан асуудлаар иргэдтэй санал солилцож, тэдэнд хариулт өгдөг тогтолцоо бүрдүүлнэ, иргэдийн санал хүсэлт, өргөдөлд тавьсан асуудлыг бодитойгоор

хэрэгжүүлэн, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, төр иргэдийн холбоог бэхжүүлэх ажлыг өргөтгөнө, иргэд сум орон нутгийн ашиг сонирхол хөндөгдөн байгаа тал болон иргэдийн санал бодолд тулгуурлан асуудлыг шийдвэрлэнэ гэсэн зорилтууд дэвшүүлж энэ хүрээнд зарим ажлууд хийгдэж байна.

**Хүснэгт 1. ЗД-ын шийдвэр гаргахдаа иргэдийн саналыг тусгах байдал**

	Сумын ЗД	Аймгийн ЗД
Тусгадаг	33,3	16,2
Тусгадаггүй	27,8	29,9
Мэдэхгүй	38,9	53,9
Нийт	100%	100%

Хэнтий аймагт аймгийн ЗДТГ-аас иргэдтэй санал солилцож, тэдэнд хариулт өгдөг 23303 гэдэг мэдээллийн утас ажиллуулж эхэлжээ. Ийм ажил Булган аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байна. Мөн Булган аймагт нутгийн удирдлагын байгууллагын үйл ажиллагааг иргэдэд үр өгөөжтэй мэдээлдэг сум шалгаруулдаг болзол гарган өнгөрсөн жилээс хэрэгжүүлсэн. Түүнчлэн зарим сумдад иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч хариу өгөх ажилтан ажиллуулах, саналын хайрцаг ажиллуулах санаачлага гарч байна.

Нутгийн захиргааны байгууллагуудаас дээрх санаачлагууд гарч, үйл ажиллагааны төлөвлөгөөнд нь тусгагдаж, зарим нь хэрэгжиж буй явдал нь ЗДТГ, ИТХ-ын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, иргэдийн оролцоог сайжруулахад одоо мөрдөж буй хууль, дүрэм журмаас гадна шийдвэр гаргагчдын иргэдийн оролцоог дэмжин хөтөлөгч хандлага, ажил хэрэгч санаачлага, бодит ажлууд хэрэгжиж, цаашлаад хэлбэршиж тогтворжих нь чухал байгааг илтгэж байна.

Судалгаанд оролцогчдын 60,1 хувь нь сумын засаг дарга, 41,7 хувь нь аймгийн засаг дарга үйл ажиллагааныхаа тайланг тавьдаг гэж хариулжээ. 33.3 хувь нь сумын ЗД-ын шийдвэрт, 16.2 хувь нь аймгийн

ЗД-ын шийдвэрт иргэдийн саналыг тусгадаг гэж хариулсан байгаа нь ЗД нарын зүгээс иргэдийн санаа бодлыг сонсох, зөвлөлдөх байдал тааруухан байгааг илтгэж байна.

... газрын асуудлыг шийдэхэд иргэд оролцох нэн шаардлагатай байна. Гэтэл засаг дарга нар иргэд оролцох явдалд тун дургүй. Саналаа хэлэхээр «Чи мэддэг юм уу? Би мэддэг юм» гэж хариулдаг. Юм хэлээд ямар ч нэмэргүй

(Иргэдтэй хийсэн ярилцлагаас)

Нутгийн захиргааны байгууллагын түвшин өгсөх тусам тэдгээрийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар иргэд мэдээлэлгүй, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нь чиглэсэн саналаа илэрхийлэх, хяналт тавих, үнэлэн дүгнэх боломж буурч байна.

### МЭДЭЭЛЭЛГҮЙ ИРГЭН

Нутгийн удирдлагын талаарх мэдээлэл иргэдэд хүрэхгүй, иргэд мэдээлэл олж авах эрхээ хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал байгаа нь удирдлагын бүхий л түвшинд оролцох оролцоонд сөргөөр нөлөөлж байна. Иргэдийн 50 гаруй хувь нь нутгийн удирдлагын талаар мэдээлэл хангалтгүй буюу авдаггүй гэжээ. Аймгийн ИТХ, ЗД-ын шийл ажиллагааны талаарх мэдээлэл иргэдэд хамгийн хүртээмжгүй, олж авахад бэрхшээлтэй байдаг бол багийн ИНХ, ЗД-ын тухайд харьцангуй ойр дөт болдог ажээ. Иргэд нутгийн удирдлагын холбогдох байгууллагын талаар мэдээлэл олж авах нь удирдлагын хүнд суртал, хаалттай байдал, намчирхал их болон холбогдох хууль өдий хир үгүй байгаагаас хамаарч байна.

Нутгийн удирдлагаас нийтлэг байдлаар мэдээллийн нээлттэй танхим ажиллуулах, мэдээлэл түгээх талаар тодорхой санаачлагууд хэрэгжиж

эхэлж байгаа ч аймаг, сумын ИТХ, ЗДТГ-т мэдээлэл түгээх тогтсон уламжлал, горим гэхүйц зүйл алга байна. Нутгийн удирдлагаас мэдээллийг гол төлөв хэвлэл мэдээллийн хэрэгслүүд (ялангуяа зурагт, сонин), хурал-яриа таниулгын ажил, мэдээллийн самбар ажиллуулах зэргээр түгээдэг.

#### ИТХ-ын талаар иргэдийн мэдээлэл олж авах боломж

	Сумын ИТХ	Аймгийн ИТХ
Сайн мэдээлэлтэй	17,5	12,1
Дунд зэрэг	34,8	28,4
Хангалтгүй	47,7	59,5
Нийт	100%	100%

Тухайлбал багт хурал ИНХ болон яриа таниулга нь иргэдийн мэдээлэл олж авах гол хэрэгсэл болж байна.



Түүнчлэн иргэдийн 42,5 хувь нь «бусад хүмүүсийн ярианаас» нутгийн удирдлагын байгууллагуудын талаархи мэдээллийг олж авдаг гэж хариулжээ.

**Орон нутгийн удирдлагын талаархи мэдээллийг олж авдаг сувгууд**

	Тоо	Хувиар
Мэдээллийн самбар	87	22,4
Зурагт	143	36,9
Радио	50	12,9
Яриа таниулгын ажил	118	30,4
Хурал	153	39,4
Тараах хуудас	17	4,4
Веб хуудас	4	1,0
Бусад хүмүүсийн яриа	165	42,5
Огт авдаггүй	28	7,2

Ихэнх аймгууд нь орон нутгийн сонин, телевиз, ФМ радиотой. Гэхдээ орон нутгийн ТВ, ФМ радиогоор дамжуулж буй мэдээллийг зөвхөн сум (тун ховор), аймгийн төвийн иргэд л хүлээн авах боломжтой байх бөгөөд орон нутгийн сонин төлбөртэйн сацуу харьцангуй цөөхөн дугаар гардаг зэрэг нь мэдээллийг хүртээмжтэй болгож чадахгүй байна. Орон нутгийн сонинг худалдан авдаг эсвэл захиалдаг иргэд ч харьцангуй цөөн. ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэх асуудлын талаар иргэдэд мэдээлэх, сурталчилах явдлыг аймаг, сумдын хурлын дэгүүдэд тусгагдаагүй бөгөөд

нутгийн удирлагын хийсэн ажил, гаргасан шийдвэрийн талаарх мэдээллийг түгээдэг л туршлага өнөөдөр хэрэгжиж байна.

Нутгийн удирлагад оролцох боломж хязгаарлагдмал бөгөөд түүний талаарх мэдээлэл хүртээмжгүй, түүнчлэн иргэдийн иргэний боловсролын доогуур байгаа нь нэг талаас орон нутгийн иргэдийг нутгийн удирлагаас хөндийрч хүнийсэх, нөгөө талаас нутгийн удирлагын бодлого, үйл ажиллагааны үр нөлөө буурах үр дагаварт хүргэх болно.

**НУТГИЙН УДИРДЛАГА БА ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУД**

Орон нутаг дахь иргэний нийгмийн байгууллагуудын чадавхи, үйл ажиллагааны хамрах хүрээ, санхүүгийн байдал сул байгаа нь шийдвэр гаргах үйл явцад оролцох, бүлгийн болон нийтийн эрх ашгийг нэгтгэж илэрхийлэх, хэрэгжүүлэхэд ихээхэн бэрхшээл учруулдаг ч нэг талаас нутгийн удирдлагад бодлогын үйл явцад ИНБ-ыг оролцуулах сонирхол, хандлага төлөвшөөгүй, нөгөө талаас ИНБ-ын зүгээс хүчтэй шаардлага тавьж оролцох арга замаа төдийлэн эрэлхийлдэггүй нь гол саад болж байна.

Иргэдийн хамгийн сайн мэддэг байгууллага бол ядуурлыг бууруулах чиглэлээр ажиллаж буй ТББ-ууд байна. Иргэдийн олонхи нь Дэлхийн Зөн байгууллагыг болон түүний салбар ТББ-уудыг нэрлэсэн байна. Иргэдийн хувьд Дэлхийн зөнг ТББ-ын сайн жишээ, иргэдэд хүрч юм хийж байгаа байгууллага хэмээн үнэлэх явдал нийтлэг байв.

Орон нутгийн ТББ-ууд иргэдэд хэрэгцээтэй байгаа үйлчилгээг хүргэхэд түлхүү анхаарч, төрийн чиг үүрэг, ачааллыг хуваалцаж байна. Харин



орон нутгийн шийдвэр гаргагчдад нөлөөлөх, тэдэнд хяналт тавих чиглэлд ТББ-ууд төдийлэн ажилладаггүй байна. ТББ-ууд нь орон нутгийн иргэдийн адилаар шийдвэр гаргах үйл явцад төдийлэн оролцож чаддаггүй бөгөөд төрд хяналт тавьж, ард иргэдийн эрх ашиг, эрхийг хамгаалах чиглэлд идэвхтэй ажилладаг ТББ бараг алга байна гэж дүгнэж болохоор байна.

... ИНБ-ууд мөнгө гуйхаа л мэддэг. Иргэдийг хөдөлгөж нөлөөлөх үүрэгтэй гэдгээ мэддэггүй, ухаардаггүй.

*(Аймгийн ИТХ-ын төлөөлөгчтэй хийсэн ярилцлагаас)*

Орон нутгийн удирлагын иргэний нийгмийн байгууллагуудын талаарх ерөнхий үнэлгээ, хандлага нилээд сөрөг буюу иргэний нийгмийн байгууллагуудын чадавхи сул, идэвхтэй тогтвортой үйл ажиллагаа бага хэмээн дүгнэх явдал нийтлэг байна. Нутгийн удирдлагын хувьд уламжлалт гэгдэх Ахмадын, Эмэгтэйчүүдийн, Хөгжлийн Бэрхшээлтэй иргэдийн, Хүүхдийн байгууллагатай, сүүлийн жилүүд хүмүүнлэгийн чиглэлийн ТББ-уудтай зарим үйл ажиллагаа хамтран явуулах, арга хэмжээ зохион байгуулах хүрээнд л иргэний нийгэмтэй хамтран ажиллаж байна. Төр-иргэний нийгмийн байгууллагууд хамтран ажиллах, бодлого, шийдвэр боловсруулж гаргахад иргэний нийгмийн байгууллага үр нөлөөтэй оролцоонд саад болж буй олон хүчин зүйлс орон нутагт байна. Юуны өмнө хоёр талын харилцан итгэлцэл, хамтран ажиллах нийтлэг зарчим төлөвшөөгүй байна. Улс төр дэх намчирхал иргэний нийгэмд халдварлаж энэ нь эрүүл бус харилцааг бий болгож байна. Орон нутгийн удирдлагын иргэний нийгмийн талаарх хандлага, иргэний нийгмийн байгууллагуудын нутгийн удирдлагын талаарх хандлага үнэлгээ ихээхэн зөрчилтэй байна.

Ер нь иргэд, иргэний нийгмийн байгууллагын хувьд орон нутгийн шийдвэр гаргах явцад идэвхтэй оролцох, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхэд нутгийн удирдлагын зүгээс олон янзын дарамт, ялгаварлал байгааг иргэд ч, ТББ-ууд ч олонтаа өгүүлж байгаа нь төр-иргэний үр нөлөө бүхий харилцаанд бэрхшээл үүсгэж байна.

## ДҮГНЭЛТ

- Тухайн багийн нийт иргэд шууд оролцож болох нутгийн өөрийн удирдлагын анхан шатны байгууллага ИНХ-д иргэдийн оролцооны түвшин маш доогуур байгаа нь хурлын хэлэлцэн шийдвэрлэх асуудлын хүрээ маш хязгаарлагдмал, холбогдох мэдээллийн хүртээмж муу байдгаас хамаарч байна. ИНХ нь иргэдийн хуран цугларч, нийтлэг асуудлаа хэлэлцэн шийдэх эс бөгөөс дээш уламжлах, иргэд нэгдэх, хамтран ажиллах сонирхол, сэдэл, хандлагыг бий болгосон нөхцөлийг бүрдүүлэхгүйгээр нутгийн өөрийн удирдлагыг жинхэнэ утгаар хэрэгжүүлэх боломжгүй болжээ.
- Аймаг, сумын ИТХ-ын түвшинд шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоо хангалтгүй байна. ИТХ-ын хаалттай байдал, иргэдийн төлөөлөгчдийн иргэдийн төлөөлөлгүй болсон явдал нь үр нөлөө бүхий иргэний оролцоо нэмэгдэхэд тээг болж байна. Монгол улсын холбогдох хуулиуд болон аймаг, сумдын хурлын дэгд хийсэн шинжилгээнээс үзвэл иргэдийн шийдвэр гаргах үйл явц дахь оролцоог төдийлэн анхааралгүйгээр орхигдуулсан эс бөгөөс хязгаарласан байдалтай байна. ИТХ-ын төлөөлөгчөөр дамжуулан санал дэвшүүлэх, хурлын хуралдаанд ажиглагчаар оролцох гэсэн өнөөгийн эрх зүйн хүрээн дэх оролцооны хэлбэр иргэдийн оролцоог хангах ямар ч боломжгүй байна. Учир нь иргэдийн төлөөлөгчид иргэдтэй ажиллахгүй байна. Иргэдийн 70 гаруй хувь нь сонгосон төлөөлөгчтэйгээ нь сонгогдсоноос хойш огт уулзаагүй гэсэн бол 30 гаруй хувь нь аймгийн ИТХ-ын төлөөлөгчөө огт танихгүй гэсэн байна. Хуралд хэн оролцохыг иргэдийн хүсэлтээр биш хурлын дарга, тэргүүлэгчдийн урилгаар шийддэг нь оролцоог дэмжих бус хязгаарлаж байгаа хэрэг юм.
- Өнөөдөр үйлчилж буй эрх зүйн зохицуулалтаар орон нутгийн нийгэм эдийн засгийн үйл ажиллагааг зохицуулах харьцангуй өргөн эрх эдлэж буй Засаг даргын түвшин дэх шийдвэр гаргах үйл явцад иргэдэд мэдээлэл өгөх, тэдэнтэй зөвлөлдөх, тайлагнах тогтмолжиж хэвшсэн бүтэц, удирдлагын арга барил, эрх зүйн босго шаардлага байхгүй нь иргэдийн оролцооны үр нөлөөг бууруулж, хязгаарлахад хүргэж байна. ФМ радиогаар иргэдтэй уулзах, санал шүүмжлэлийн утас ажиллуулах, өргөтгөсөн хурал зохион байгуулах зэрэг санаачлагууд хэрэгжиж буй нь энэ чиглэлд хийгдэх алхамууд мөн бөгөөд эдгээрийг эрх зүйн болон институцийн түвшинд бэхжүүлж өгөх шаардлагатай байна.
- Орон нутаг дахь иргэний нийгмийн байгууллагуудын чадавхи, үйл ажиллагааны хамрах хүрээ, санхүүгийн байдал сул байгаа нь шийдвэр гаргах үйл явцад оролцох, бүлгийн болон нийтийн эрх ашгийг нэгтгэж илэрхийлэх, хэрэгжүүлэхэд ихээхэн саад болж байгаа ч нэг талаас нутгийн удирдлагад бодлогын үйл явцад ИНБ-ыг оролцуулах сонирхол, хандлага төлөвшөөгүй, нөгөө талаас ИНБ-ын зүгээс хүчтэй шаардлага тавьж оролцох арга замаа төдийлэн эрэлхийлдэггүй нь том тээг болж байна.



## ЗӨВЛӨМЖ

1. Багийн ИНХ дахь иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд ИНХ зохион байгуулж буй арга хэлбэр, мэдээлэл түгээлт, хэлэлцэх асуудлыг эргэн харах хэрэгтэй байна. Багийн ИНХ-ыг төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаар мэдээлэл түгээх хэлбэрийг өөрчлөн, иргэдийн хамтаараа хэлэлцэж, хамтын шийдэлд хүрэх бодит хэлэлцүүлэг болгон зохион байгуулахад анхаарах хэрэгтэй. Нутгийн удирлагын байгууллагуудад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нэг томоохон хөшүүрэг нь эрх мэдлийн төвлөрлийг сааруулж орон нутагт эрх мэдэл шилжүүлэх явдал бөгөөд ялангуяа иргэдийн шууд оролцоогоор хэрэгжиж байдаг. ИНХ-ын эрх хэмжээг нэмэгдүүлэх, бие даасан байдлыг хангах хэрэгтэй.
2. Аймаг, сумын ИТХ-ын хуралдаанд иргэдийн оролцох боломж, хүрээг өргөжүүлэх хэрэгтэй. Үүний тулд нэгд, ИТХ-ын хуралдаанд иргэд өөрийн хүсэлтээр оролцох (саналын эрхгүй), иргэдийн нийтлэг, бүлгүүдээс хуралд асуудал санаачлан оруулах боломжийг бүрдүүлсэн зохицуулалтыг холбогдох хууль болон дэгд өөрчлөлт оруулах замаар хэрэгжүүлэх, хоёрдугаарт ИТХ-ын хуралдаанаар орон нутгийн төсөв болон нийгэм эдийн засгийн тулгамдсан иргэдийн нийтлэг эрх ашигт хамаарах асуудлыг шийдвэрлэхийн өмнө Нээлттэй сонголт хийх шаардлага буюу босгыг хурлын дэгд суулгах шаардлагатай.
3. ЗД-ын зүгээс иргэдтэй зөвлөлдөх, тайлагнах тогтмолжиж хэвшсэн бүтцийг орон нутаг дахь төрийн удирлагад бий болгоход анхаарах, ялангуяа орон нутагт мэдээллийг түгээх (мэдээллийн олон сувгийг ашиглахын сацуу тэдгээрийг тогтмолжуулах), иргэдийн иргэний боловсролыг дээшлүүлэх (мэдээллийн төв ажиллуулах, идэвхжүүлэх), иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллахад санаачлага гарган хэрэгжүүлэх хэрэгтэй.
4. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Удирдлага, санхүүжилтийн тухай, Төсвийн тухай зэрэг орон нутгийн удирлагад холбогдох хуульд өөрчлөлт оруулж орон нутгийн бие даасан байдлыг хангах талаар УИХ, ЗГ-ын түвшинд хэлэлцэж байгаа энэ үед нутгийн удирдлага дахь иргэдийн оролцоог хангах асуудлыг орхигдуулж болохгүй юм.

### III. УДИРТГАЛ

Орон нутгийн түвшинд шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангах нь ардчиллыг хөгжүүлэх, ядуурлыг бууруулах, төрийн үйлчилгээг сайжруулах, хөгжлийн бусад санаачлагуудыг амжилттай хэрэгжүүлэх түлхүүр гэдгийг өнөөдөр хүн бүр хүлээн зөвшөөрч байна. Үндэсний түвшинд сонгуулийн ба төлөөллийн ардчилалд илүү анхаарч байсан бөгөөд харин авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд жирийн иргэдийн амьжиргааг сайжруулахад мэдэгдэхүйц нөлөөлж чадаагүйг харгалзан үзэж өнөөдөр иргэдийн оролцоо ба орон нутгийн түвшин дэх үр ашигтай ил тод, хариуцлагатай тогтолцоонд анхаарал төвлөрүүлэх болсон<sup>1</sup>.

Монгол улсын Үндсэн хуулийн 3-р зүйлийн 1-д Монгол улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдлэнэ гэж заасан байдаг нь иргэдийн шийдвэр гаргах үйл явцад оролцох эрхийг хуульчлан баталгаажуулсан хэрэг юм.

Монгол улсын шинэ засгийн газар болон ерөнхийлөгч бүрийн мөрийн хөтөлбөрт, мөн төрөөс ардчилал, сайн засаглалыг бэхжүүлэх, эмэгтэйчүүд, нийгмийн хамгаалал, хүн амын зэрэг асуудлаар баримтлах бодлогын баримт бичгүүдэд иргэний оролцоо, төрийн бус байгууллагыг дэмжинэ, хамтарч ажиллана, оролцоог нь нэмэгдүүлнэ гэсэн заалтууд байдаг<sup>2</sup>. 2003 онд Монголд болсон Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнууд (АШСТО)-уудын олон улсын V бага хурлаас гаргасан Улаанбаатарын тунхаглалд “Бид иргэний нийгэм болон засгийн газар хоорондын түншлэлийг дэмжин урагшлуулах болно. Энэ зорилгоор бид орон нутгийн болон үндэсний түвшинд шийдвэр гаргах үйл явцад иргэний нийгмийг өргөнөөр татан оролцуулах үүрэг хүлээж байна.” гэж хүлээн зөвшөөрсөн байна. Эдгээр нь өнөөгийн хэрэгцээ, цаашдын үр нөлөөг харгалзан боловсруулагдсан утгаараа төр-иргэний нийгмийн харилцаа, хамтын ажиллагааг сайжруулах, төрийн бодлого

<sup>1</sup>Жон Киуага-Нсүбүга. Орон нутгийн түвшинд ардчиллыг бэхжүүлэх нь: тулгамдсан зарим асуудлын судалгаа. Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын олон улсын V бага хурал: Судалгааны ажлууд ба төгсгөлийн баримт бичгүүдийн эмхтгэл. УБ: 2003, 70-р хуудас.

<sup>2</sup>2000-2004, 2004-2006 оны Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Монгол улсын ерөнхийлөгчийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр 2005. Төрөөс хүн амын талаар баримтлах бодлого 1996 он. Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр 2000 он.



боловсруулахад иргэний нийгмийн оролцоо, үр нөлөөг нэмэгдүүлэх нь маш чухал асуудал болохыг төр хүлээн зөвшөөрч буйн илэрхийлэл юм. Гагцхүү түүний хэрэгжилт тун хангалтгүй байсаар ирсэн нь харамсалтай.

Үр нөлөө бүхий идэвхтэй оролцоо, шийдвэр гаргах шатанд санал өгөх тэгш эрх, боловсруулж буй хөтөлбөр, асуудлыг хянах чадвар, бүрэн цогц ойлголт, мэдлэг зэрэг нь ардчилсан үйл явцын шалгуур болж байдаг. Иргэдийн оролцоо нь дараах давуу талуудыг буй болгож байдаг. Үүнд:

### **1. Төрийн бодлого сайжирна:**

Төр, иргэдийн харилцаа бат бэх байхын хэрээр иргэдийг нийгмийн асуудлуудад цаг зав, хүч чармайлтаа зориулахад нь зоригжуулдаг бөгөөд төр ч гэсэн иргэдийн оролцоог нэмэлт боломж хэмээн үнэлэн үзэж ашигладаг. Иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, оролцоо нь төр, засгийн газарт бодлогоо боловсруулах илүү тулхтай суурь нөхцөлийг бүрдүүлж өгөхөөс гадна түүнийг аливаа шинэ зүйлд суралцдаг байгууллага болгон хувиргадаг.

### **2. Төрд итгэх итгэл нэмэгдэнэ:**

Иргэдийн мэдээлэл, зөвлөгөөн, оролцоо нь төрийн бодлогын шинжтэй хөтөлбөр, төлөвлөгөөний талаар илүү мэдээлэлтэй болох, санал бодлоо илэрхийлэх, шийдвэр гаргах явцад хувь оролцоогоо нэмэрлэх боломжийг тэдэнд бүрдүүлдэг бөгөөд ийм оролцооны дүнд бий болсон бодлогын үр дагаврыг иргэд хүлээн зөвшөөрч дэмжих явдал нь ч нэмэгддэг.

### **3. Ардчилал улам бэхжинэ:**

Төр иргэдийн харилцаа бэхжих нь иргэдээс нийгмийн амьдралд оролцоо нөхцөлийг бүрдүүлж, тэдний оролцоог идэвхжүүлдэг<sup>3</sup>. Иргэдийн оролцоог дээшлүүлснээр ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэх, нөөцийг үр ашигтай хуваарилахад нөлөөлж байдаг.

Орон нутгийн түвшинд иргэдийн оролцоо маш чухал гэдгийг ихэнх төрийн түшээд, албан хаагчид мэдэж хүлээн зөвшөөрдөг ч яагаад иргэдийг оролцуулах явдал хангалтгүй байж ирсэн бэ?<sup>4</sup> . Нөгөө талаас иргэд оролцоог чухал гэж мөн үзсэн боловч оролцооны түвшин яагаад доогуур байна вэ?<sup>5</sup> .

Дээрх нөхцөлд орон нутагт бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог хангаж буй ямар арга барилууд байгаа, цаашид аймаг, сум, багийн засаг захиргаа, Иргэдийн Төлөөлөгчдийн

<sup>3</sup>ЭЗХАХБ. Иргэн түншлэгч болох нь: бодлого боловсруулах явцад мэдээлэх, зөвлөлдөх, олон нийтийг оролцуулах. Гарын авлага. УБ: МННХ. 2003

<sup>4</sup>Тухайлбал бидний судалгаанд оролцож ярилцлага өгсөн нийт 24 хүн (ИТХ-ын төлөөлөгч, Засаг дарга нар, ЗДТГ-ын ажилтан) бүгд шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог чухал хэмээн үзэж байлаа.

<sup>5</sup>Бидний асуулгад оролцсон нийт хүмүүсийн 88.9 хувь нь оролцоог чухал гэж үзсэн бол зөвхөн 4.1 хувь нь л оролцоо шаардлагагүй гэсэн байна.

хурлын түвшинд хэрэгжүүлж болохуйц ямар арга замууд байж болохыг тодорхойлж, төр-иргэний тогтвортой, нээлттэй, үр ашигтай харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх бодлогын зөвлөмжийг боловсруулах явдал энэ судалгааны зорилго болно.

Энэхүү зорилгын хүрээнд бид дараах зорилтуудыг хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Орон нутгийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэний оролцооны түвшин, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох
2. Орон нутгийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэний оролцоог зохицуулж буй өнөөгийн эрх зүйн орчин, түүний давуу сул талуудыг илрүүлэх
3. Орон нутгийн шийдвэр гаргах үйл явц дахь оролцооны талаар иргэд ямар мэдлэг, хандлагатай байгааг тодорхойлох
4. Орон нутгийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн оролцоо, үр нөлөөг нэмэгдүүлэх механизмуудыг тодорхойлж, оролцоог сайжруулах талаар зөвлөмж боловсруулах



## IV. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

### СУДАЛГААНЫ ТААМАГЛАЛ

Орон нутаг дахь иргэдийн оролцоо сул байгаагийн гол шалтгаан нь оролцоог хангахад чиглэсэн өнөөгийн эрх зүйн зохицуулалт, удирдлагын арга барил болон иргэдийн оролцооны талаарх иргэдийн хандлага, мэдлэг сөрөг үзүүлэлттэй байгаа гэсэн үндсэн таамаглал дэвшүүлсэн.

### СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

Судалгаанд Монголын хөдөөгийн гурван аймаг тухайлбал: Архангай, Булган, Хэнтий аймгийн төв, 6 сум, мөн багууд хамрагдсан. Судалгааны баг чанарын болон тоон судалгааны аргыг хэрэглэж, эрх зүйн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийн, ганцаарчилсан ба фокус бүлгийн ярилцлагууд авч, анкетийн судалгаа хийлээ. Судалгааны явцыг нарийвчлан харья. **Үүнд:**

#### 1. Ганцаарчилсан ярилцлага (хагас бүтэцлэгдсэн асуулт бүхий):

Аймаг сум, багийн засаг даргын тамгын газар болон ИТХ-ын төлөөлөлтэй уулзаж ярилцсан. (Нийт 24 хүнтэй ганцаарчилсан ярилцлага хийсэн) Ярилцлагаар төрийн албан хаагчдын иргэний

нийгмийн талаархи ойлголт хандлага, хамтран ажиллах, бодлого, шийдвэрт оролцуулах сонирхол, үйлчилж буй эрх зүйн зохицуулалт, институтчиллын талаархи үнэлгээ дүгнэлтийг илрүүлэхэд чиглэсэн. Мөн иргэд төрийн байгууллагатай харилцахад гардаг бэрхшээл, болгоомжлол, итгэлцлийн талаархи байр суурийг илрүүлэхэд чиглэв.

#### Ганцаарчилсан ярилцлагын түүвэр

	Хэнтий	Булган	Архангай
Аймгийн ЗДТГ, ИТХ	4	4	4
Сумын ИТХ, ЗДТГ	2	2	2
Багийн Засаг дарга	2	2	2
Нийт	8	8	8
<b>НИЙТ</b>		<b>24</b>	



## 2. Баримт бичигт шинжилгээ хийх:

Нутгийн удирдлага, орон нутгийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэний оролцоонд холбогдох хууль, эрх зүйн актууд, 3 аймаг, 9 сумын ИТХ-ын дэг, засаг даргын мөрийн хөтөлбөр, засгийн газрын мөрийн хөтөлбөр, олон улсын тунхаглал хөтөлбөрүүдэд агуулгын дүн шинжилгээ хийсэн.

## 3. Фокус бүлгийн ярилцлага:

Иргэд, төрийн бус байгууллагын төлөөлөлтэй ярилцлага хийсэн. 1-рт аймаг тус бүрт иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн тус бүр 1 бүлгийн ярилцлага хийлээ. Мөн аймаг тус бүрд 8 оролцогч бүхий 5 цуврал ярилцлага хийсэн. Аймгийн төвийн иргэдийн төлөөлөл бүхий нийт 3 ярилцлага, сумын төвийн багийн иргэдийн 6 ярилцлага, хөдөөний багийн иргэдийг оролцуулсан 6 ярилцлага явуулав. Ярилцлагыг хүйс, насны хувьд нэг бүлэг болгох байдлаар зохион байгуулав. Бодлогын үйл явцад оролцоход учирдаг саад бэрхшээл, цаашид бий болгох шаардлагатай эрх зүйн зохицуулалт болон институтчилсан механизмын талаархи байр суурь хандлагыг илрүүлэхэд ярилцлага чиглэгдэж байв.

### Фокус бүлгийн ярилцлагын түүвэр

	Хэнтий	Булган	Архангай
Аймгийн нэр	1 эр	1 эм	1 холимог
2 Сумын иргэд	2(нэг баг нь эм, нөгөө баг нь эр)	2(нэг баг нь эм, нөгөө баг нь эр)	2(нэг баг нь эм, нөгөө баг нь эр)
2 багийн иргэд	2(нэг баг нь эм, нөгөө баг нь эр)	2(нэг баг нь эм, нөгөө баг нь эр)	2(нэг баг нь эм, нөгөө баг нь эр)
Нийт	40	40	40
<b>НИЙТ</b>		<b>120</b>	


## 4. Анкетын судалгаа:

3 аймгаас нийт 388 иргэдийг хамарсан анкетын судалгаа авсан. Судалгаагаар орон нутгийн шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн оролцооны өнөөгийн түвшин, ойлголт, төсөөлөл, оролцооны хэлбэрүүд, оролцоход учирдаг саад бэрхшээлийг илрүүлэхийг зорив.




## АНКЕТЫН СУДАЛГААНЫ ТҮҮВЭР:


**График 1.** Анкетын судалгаанд оролцогчдын насны байдал




**График 2.** Анкетын судалгаанд оролцогчид, аймгаар



**График 3.** Анкетын судалгаанд оролцогчид, байршлаар



**График 4.** Анкетын судалгаанд оролцогчид, боловсролын түвшингээр



## V. МОНГОЛ УЛСЫН НУТГИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО

Монгол улс засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд аймаг, нийслэлд, аймаг нь сумдад, сум багуудад, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороодод хуваагдаж байна. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоо нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал, тухайн Хурлын хуралдааны чөлөө цагт түүний Тэргүүлэгчид, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргаас бүрдэж байна.


Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан зохион байгуулахаар хуулинд заасан байдаг<sup>6</sup>. Нутгийн өөрөө удирдах байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (ИТХ), баг, хороонд иргэдийн Нийтийн хурал (ИНХ), тухайн Хурлын хуралдааны чөлөө цагт түүний Тэргүүлэгчид байдаг. Аймгийн ИТХ-ын төлөөлөгчид тухайн аймгийн хүн амын тооноос хамаарч 25-35 хүн байдаг бол сумдынх 15-25 хүн байдаг.

Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга нь тухайн нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий засаг төрийн төлөөлөгч болдог. Баг, хороо, сум, дүүргийн Засаг даргыг тухайн хурлаас нэр дэвшүүлж дээд шатны Засаг дарга дөрвөн жилийн хугацаагаар, аймаг, нийслэлийн Засаг даргыг тухайн Хурлаас нэр дэвшүүлж Ерөнхий сайд дөрвөн жилийн хугацаагаар тус тус томилдог. (Бүдүүвч 1.)

ИТХ нь ард иргэдээс шууд, ардчилсан зарчим дээр тулгуурлан сонгогддог тухайн засаг захиргааны нэгжийн иргэдийн төлөөллийн байгууллага юм. Энэ утгаараа улс төрийн хариуцлагыг оршин суугчдын өмнө бүрэн хариуцах ёстой бол засаг дарга нь хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт төв засгийн газрын төлөөлөгчийн үүргийг орон нутагт гүйцэтгэж, дээд шатны засаг дарга болон Засгийн газрын өмнө хариуцлага хүлээх ёстой байдаг.

<sup>6</sup> Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль. 2-р бүлгийн 8-р зүйл





## VI. ОДОО ХЭРЭГЛЭГДЭЖ БУЙ МЕХАНИЗМУУД БА ОРОН НУТГИЙН ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦ ДАХЬ ИРГЭДИЙН ОРОЛЦОО

### 1. БАГИЙН ТҮВШИН ДЭХ ИРГЭДИЙН ОРОЛЦОО

Тухайн багийн нийт иргэд шууд оролцож болох нутгийн өөрийн удирдлагын анхан шатны байгууллага болох ИНХ-д иргэдийн оролцооны түвшин бусад дээд шатны байгууллагатай харьцуулахад харьцангуй өндөр ч, маш доогуур цэцэглэлттэй байна. Судалгаанаас үзэхэд аймаг, сумын төвийн хувьд багийн ИНХ-ын ирц ихэнх тохиолдолд хангалтгүй, заримдаа ирц бүрддэггүй, тогтоосон хэмжээнд хүрдэггүй байна. Энэ нь хурлын хэлэлцэн шийдвэрлэх асуудлын хүрээ маш хязгаарлагдмал, холбогдох мэдээллийн хүртээмж муу байдгаас хамаарч байна. Иргэдэд нэгдэх, хамтран ажиллах сонирхол, сэдэл, хандлага төлөвшөөгүй, ИНХ-ын эрх мэдэл хязгаарлагдмал байгааг хүлээн зөвшөөрдөггүй, хурлаас гарах эцсийн үр дүн, холбогдох шийдвэрийг хардаггүй байна. Багийн ИНХ-ын хэв загвар, хэлэлцэх асуудал нь олон нийтийн оролцоог дэмжихэд чиглэгдэж чаддаггүй байна. ИНХ-ын дарга, тэргүүлэгчдийн иргэний нийгмийн талаарх мэдлэг тааруу, олон түмэнд хүрч ажиллах, мэдээллийн хүртээмж муу байгаа нь энэ нөхцөл байдлыг бий болоход нөлөөлж байна. Иргэдийн багийн ИНХ дахь оролцоо нь оршин буй нутаг дэвсгэр, нас, хүйсээс хамааралтай байна.

Монгол улс засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд аймаг, нийслэлд, аймаг нь сумдад, сум багуудад, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороодод хуваагдаж байна. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоо нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал, тухайн Хурлын хуралдааны чөлөө цагт түүний Тэргүүлэгчид, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргаас бүрдэж байна.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан



зохион байгуулахаар хуулинд заасан байдаг<sup>7</sup>. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж бүр нь өөрийн харьяа иргэдтэй бөгөөд тэдгээрийг төлөөлсөн хурлууд төлөөллийн ардчиллын зарчмаар ажиллах чиг үүрэгтэй юм. Харин баг, хорооны ИНХ бол тухайн баг, хорооны сонгуулийн насны нийт иргэд шууд оролцож болох нутгийн өөрийн удирдлагын анхан шатны байгууллага юм.

Иргэд багийн ИНХ-аараа юу хэлэлцэж шийдэх эрхтэйг уг хуульд дараах байдлаар заасан байна. Үүнд:

1. Баг, хорооны Засаг даргыг томилуулахаар нэр дэвшүүлэх, чөлөөлүүлэх, огцруулахаар сум, дүүргийн Засаг даргад санал тавих,
2. Хурлын дотоод зохион байгуулалтын асуудал хэлэлцэн шийдвэрлэх,
3. Шаардлагатай гэж үзвэл баг, хорооны Засаг даргын ажлын тайлан сонсох,
4. Баг, хорооны иргэдийг шагнаж урамшуулах, тусламж үзүүлэх,
5. Өрхийг албан татвар, бусад ногдол үүргээс түр чөлөөлөх буюу хөнгөлөлт үзүүлэхээр санал тавих,
6. Иргэний үндсэн болон журамт үүргийн биелэлтийг хангуулах

Баг, хорооны Засаг даргыг томилуулахаар нэр дэвшүүлэх, чөлөөлүүлэх, огцруулах санал тавихаас бусад эрх хэмжээг хуралдааны чөлөө цагт хурлын Тэргүүлэгчид эдэлдэг байна. ИНХ нь жилд 2-оос доошгүй удаа хуралдана гэж хуульд заасан байна. Баг, хорооны ИНХ-д оролцсон иргэдийн олонхийн саналаар асуудлыг шийдэж тогтоол гаргаж болдог. Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуульд баг, хорооны Хурлын хуралдаанд тухайн баг, хорооны сонгуулийн насны иргэн бүр оролцож болно гэж заасан байдаг. Хуралдааныг багт 5 өрх, 50-иас дээш мянган хүн амтай сумын багт 10, хороонд 15 өрх тутмаас сонгуулийн насны тус бүр нэг хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно гэж үздэг. Засаг даргыг томилох, сум, дүүргийн Хурлын төлөөлөгч сонгохоос бусад асуудал хэлэлцэхэд баг, хорооны Хурлын хуралдааныг хэсэгчлэн хийж болдог.


Хэдийгээр хуулиар олгосон эрх хэмжээ нь тун хязгаарлагдмал боловч харьяа багийн тулгамдсан асуудлыг иргэд өөрсдөө оролцон хэлэлцэх, багийн даргад үүрэг даалгавар өгөх, дээд шатны хурал, засаг даргад саналаа уламжлах, эрх хэмжээний хүрээнд тогтоол гаргах боломжтой юм. Багийн ИНХ хуульд заасан ёсоор 2-оос доошгүй удаа хуралдана хэмээн заасан байдаг бөгөөд уг хурлыг зохион байгуулах ажлыг багийн засаг дарга хариуцдаг.

<sup>7</sup>Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль. 2-р бүлгийн 8-р зүйл


Харин судалгаанд хамрагдсан багуудын хувьд жилд хэдэн удаа хуралддаг нь баг бүрт янз бүр байна. Зарим баг жилд 4-5 удаа хурал зохион байгуулдаг бол зарим баг ялангуяа аймгийн төвүүдийн баг 1-2-аас төдийлэн хэтэрдэггүй байна. Бидний судалгаанаас үзэхэд аймаг, сумын төвийн хувьд багийн ИНХ-ын ирц ихэнх тохиолдолд хангалтгүй, заримдаа ирц бүрдэхгүй (огт хүн цуглахгүй) байх явдал нийтлэг байдаг байсан бол харин хөдөөгийн багуудын хувьд ирц харьцангуй сайн байв. Энэ нь судалгаанд оролцогчдын ИНХ дахь оролцооны талаар хариулсан хариултаас давхар харагдаж байна.

Судалгаанд оролцогчдын 37.6 хувь нь багийнхаа хуралд огт оролцдоггүй гэж хариулсан байна. Харин 17.5 хувь тогтмол, 44.8 хувь нь хааяа оролцдог байна (График 5). Багийн хуралд оролцдог иргэдийн 72.7 хувь нь жилд 1-2 удаа л оролцдог ажээ (График 6).

**График 5.** Багийн иргэдийн нийтийн хуралд иргэдийн оролцоо



**График 6.** Багийн хуралд оролцдог бол жилд хэдэн удаа оролцдог вэ?



### Багийн Иргэдийн Нийтийн Хуралд хэн идэвхтэй оролцдог вэ?

Хуралд хааяа болон тогтмол оролцогч нийт иргэд хүйсийн хувьд (эрэгтэй 30.1 хувь, эмэгтэй 32.2 хувь) үндсэндээ адил тэгш байна. Энэ харьцаа нь аймаг, сумын төв болон хөдөөд ерөнхийдөө ижил байна. Зарим хөдөөний багуудын хувьд нүүдэлчин амьдрал, багийн алслагдмал байдлаас хамаараад эрэгтэйчүүд, ялангуяа өрхийн тэргүүнүүд хуралд илүүтэй оролцдог байдал ажиглагдаж байлаа. (Жишээ 1.)

Жишээ 1. Зохион байгуулдаг газар нь хол байдаг учир хүүхнүүд нэг их оролцоод байдаггүй. Манайхны нөхрүүд оролцоо л гэдэг, ирээд хэлж байгаа юм алга л байдаг. Замдаа мартчихдаг юм байлгүй.

(Булган, Бугат сум 1-р багийн иргэдтэй хийсэн ярилцлагаас)

Насны бүтцийн хувьд хуралд оролцох байдал нилээд ялгаатай байна. Хуралд хамгийн идэвхтэй, тогтмол оролцдог иргэд бол 45-аас дээш насны иргэд байна. Судалгаанд оролцсон дээрх иргэдийн 74.8 хувь багийн хуралд оролцдог гэж хариулжээ. Иргэдийн дунд ч гэсэн багийн хуралд ахмадууд л оролцож байдаг байх гэсэн ойлголт хандлага нилээд байдаг нь нотлогдож байна. (Жишээ 2.)

Жишээ 2. Багийн иргэдийн хурал болдог үгүйг мэдэхгүй. Ахмадуудын л хурал болдог байх.

*(Хэнтий аймгийн Батноров сумын төвийн иргэдтэй хийсэн бүлгийн ярилцлагаас)*

Харин залуучуудын идэвх, оролцоо тун тааруу байгаа нь асуулга болон ярилцлагаас илэрч байна. 18-25 насныхны 55.5 хувь, 26-35 насныхны 44.0 хувь нь багийн иргэдийн хуралд огт оролцдоггүй байна. Багийн засаг дарга нартай хийсэн ярилцлагаас үзэхэд ч залуучуудын ирц оролцоог маш доогуур гэж дүгнэж болохоор байна.

Аймгуудын хувьд багийн хурал дахь иргэдийн оролцооны түвшин ерөнхийдөө ижил байна. Харин иргэдийн амьдран суугаа газраас хамаарч тэдний оролцооны түвшин нилээд ялгаатай байна. Аймгийн төвд иргэдийн хуралд оролцдог иргэд 53.6 хувьтай байхад сумын төвд 71.1 хувь, харин хөдөөд 68.0 хувьтай байна. Харин хуралд тогтмол оролцдог иргэд хөдөөд нилээд их буюу нийт иргэдийн 25.8 хувь тогтмол оролцдог бол харин аймгийн төвд зөвхөн 10.7 хувьтай байна.

Ажил хөдөлмөр эрхэлж буй эсэх, ямар ажил эрхэлдэг нь иргэдийн оролцоонд нөлөөлж байна. Тодорхой ажил эрхэлдэг иргэдийн 18.2 хувь нь хуралд тогтмол оролцдог бол ажилгүй иргэдийн 8.1 хувь нь л тогтмол оролцож байна. Ийнхүү эрхэлж буй ажил болон багийн хуралд оролцох байдлын хооронд хамаарал ажиглагдаж байна. Тэр дундаа төрийн буюу төсвийн байгууллагад ажиллагсад багийнхаа хуралд оролцох байдал илүү өндөр байна. Нөгөө талаас иргэдийн хуралд огт оролцдоггүй иргэдийн хамгийн их буюу 32.1 хувийг хувийн секторт ажиллагсад, ТББ-уудад ажилладаг иргэд 1.8 хувийг эзэлж буй нь анхаарал татаж байна. (Хүснэгт 1.)

#### Хүснэгт 1. Багийн нийтийн хурлын оролцоо, эрхэлж буй ажлаар

	Төрийн байгууллага	Хувийн сектор	ТББ	Албан бус сектор	Малчин	Нийт
Тогтмол	50,9%	9,1%	1,8%	3,6%	34,5%	100%
Хааяа	42,6%	25,5%	5,7%	0%	26,2%	100%
Огт үгүй	27,4%	32,1%	13,2%	4,7%	22,6%	100%



## Багийн Иргэдийн Нийтийн Хуралд оролцоо хангалтгүй байгаагийн шалтгаанууд

Судалгаанаас үзэхэд багийн ИНХ-д иргэдийн оролцоо муу байгаа нь иргэдийн оролцох идэвх сонирхол муу, иргэдийн нийтийн хурлын эрх хэмжээ хязгаарлагдмал, хурлын зохион байгуулалт тааруу, хурлаар хэлэлцэх асуудал тодорхой бус, шийдвэр гаргахад иргэдийн санааг тусгадаггүй, мэдээллийн хүртээмж муу, хүмүүсийн иргэний боловсролын түвшин доогуур байгаагаас шалтгаалж байна.

### 1.1 Багийн ИНХ-ын эрх хэмжээ хязгаарлагдмал байна

Хурал нь дээд шатныхаа Хурал, бусад байгууллагын эрх хэмжээнд хамаарахаас бусад нутаг дэвсгэрийн амьдралын ямар ч асуудал хэлэлцэн шийдвэрлэж болно гэж хуульд заасан нь нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад нилээд өргөн хүрээтэй эрх хэмжээ олгож буй мэт боловч дээд шатны байгууллагын эрх хэмжээнээс л байнга хамаарч байх үр дагаврыг давхар агуулж байна. Засгийн газар, түүний төв байгууллагуудын эрх мэдэл өргөжиж, харин орон нутгийн удирдлагын хумигдах болсон нь салбарын олон хуулиуд дээр ихээр ажиглагдах болсон билээ. Ийнхүү иргэдийн багийн нийтийн хуралд оролцох идэвх, сонирхол муу байгаа нь юуны өмнө багийн хурлын эрх хэмжээ тун хязгаарлагдмал, багт өөрийн төсөв хөрөнгө санхүүгийн эрх мэдэл огт үгүй байдагтай холбоотой юм. Нөгөө талаар иргэдийн хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлууд нь дээд шатны байгууллагад уламжлагдах боловч ихэнхдээ тодорхой үр дүнгүй замхардаг нь иргэдийн идэвх, сонирхлыг бууруулж байна.

Тодруулбал, хуралд огт оролцдоггүй иргэдийн давхардсан байдлаар 39.3 хувь нь оролцлоо гээд юу ч өөрчлөгдөхгүй гэж хариулсны сацуу 20 хувь нь оролцох сонирхол байдаггүй, 13.1 нь оролцоод ач холбогдолгүй гэж боддог гэсэн нь иргэдийн багийн ИНХ-д оролцох сонирхол, түүнээс хүлээх хүлээлт маш доогуур байгааг илэрхийлж байна. (Жишээ 3, 4.)

Жишээ 3. Хамгийн гол нь багийн хурлаар үр дүнтэй юм шийдэж чадахгүй хог нохой татвар гоожин нэхсээр байгаад залхаагаад очихгүй болсон юм шиг санагддаг. Уг нь бол орон нутгийнхаа сайн сайхны төлөө санаа бодлоо уралдуулж үгээ хэлэх ганц боломжтой газар чинь энэ. Бусад сум аймгийн хуралд бол иргэн санаа бодлоо илэрхийлнэ гэвэл бүтэхгүй...

(Архангай, Цахир сумын иргэдийн ярилцлагаас)

Судалгаанд оролцогчдын 46,6 хувь нь Багийн засаг даргын шийдвэрт бидний санал тусгалаа олдог гэж хариулжээ. Энэ үзүүлэлтээс харахад судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь багийн Засаг даргын шийдвэрт тэдний санал тусгалаа олдоггүй, хангалтгүй гэж үзсэн байна. Гэвч багийн Засаг даргын шийдвэр эцсийн шийдвэр байдаггүй,

ихэвчлэн дээд шатны байгууллагууд шийдсэнийг хэрэгжүүлэхэд л хүрдэг тул санал тусгагдаж байгаагийн ач холбогдол бага гэж үзэх явдал түгээмэл байв. Мөн түүнчлэн өөрсдийн идэвх оролцооноос тухайн шатны шийдвэрт иргэдийн санал тусаж байгаа эсэхийн талаарх үнэлгээ хамаарч байна. Тодруулбал судалгааны дүнгээс харахад багийн хуралд оролцдог хүмүүс багийн Засаг даргын шийдвэрт иргэдийн санал тусдаг гэж дүгнэж байв. Түүнчлэн сумын төвийнхөн болон хөдөөнийхөн багийн шийдвэрт бидний санал тусдаг гэж үзэх нь аймгийн төвийнхнөөс өндөр байна. Хэдийгээр эрх хэмжээ хязгаарлагдмал боловч багийн хурал бол иргэд олон асуудлыг хоорондоо хэлэлцэх, үзэл бодлоо уралдуулах, хамтран ажиллах, бие биенээ дэмжин туслах боломжтой газар юм.

Жишээ 4. Багийн Засаг дарга бол санал хүсэлтийг хүлээн аваад хурлаараа хэлэлцдэг. Харин суманд очоод л чимээгүй болчих юм... Багийн Засаг даргад юм хэллээ гээд шийдэж чадахгүй юм чинь очиж яах юм бэ.

*(Булган, Бугат сум, эмэгтэйчүүдтэй хийсэн бцлгийн ярилцлагаас)*

Гэвч багийн иргэдийн нийтийн хурал нь яриа таниулгын ажил мэтээр зохион байгуулагддаг нь түгээмэл. Учир нь иргэдийн нийтийн хурлаар тухайн багийн иргэдийн өмнө тулгамдаж байгаа асуудлуудыг хэлэлцэн ярилцаж тодорхой шийдэлд хүрэхээс илүү төрийн тодорхой байгууллагуудаас авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар мэдээлэл олж авах нь түгээмэл байна. /Жишээ 4,5./ Багийн дарга болон цөөн хэдэн хүн л багийн иргэдийн нийтийн хурал дээр тогтмол үг хэлдэг, бусад иргэд санал бодлоо хэлж, харилцан санал бодлоо солилцож чаддаггүй байна. Асуулгаас үзэхэд иргэдийн нийтийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэдэг үндсэн асуудлууд нь засаг даргыг сонгох, дээд төрийн байгууллагаас явуулж буй үйл ажиллагаа, цаг үеийн тулгамдсан асуудлууд, бэлчээр, татварын талаарх асуудлууд байдаг ажээ. Аль асуудал нь хурлаар тогтмол яригддаг нь аймаг, сумын төв болон хөдөөний багуудын хувьд ялгаатай байна. Тухайлбал, сумын төв ялангуяа хөдөөний багуудад татвар төлөлт, хөнгөлөлт, чөлөөлөлт зэрэг татвар хураамжтай холбоотой асуудал байнга яригддаг бол аймгийн төвд энэ асуудал төдийлэн их хөндөгддөггүй байна. Энэ нь багийн Засаг даргын эрх үүргийн хэмжээ болон иргэдийн ахуй амьдралтай илүү холбоотой юм.

Иргэдийн цаг завын боломж муутай байдал, алслагдмал нутагт амьдардаг нь багийн ИНХ дахь иргэдийн оролцоонд нөлөөлж байна. Иргэдийн 33.8 хувь нь хуралд оролцох цаг зав байдаггүй гэж хариулсан нь нэг талаас орон нутгийн иргэдийн амьдрал, ахуй нөгөө талаас иргэний идэвхтэй холбоотой юм. Хувийн секторт ажиллагсад багийн хуралд хамгийн ихээр оролцдоггүй болохыг дээр авч үзсэн бөгөөд тэдгээрийн ихэнх нь завгүйгээс хуралдаа оролцож чаддаггүй гэж хариулсан байв. Энэ нь багийн хурал гол төлөв амралтын өдрүүдэд зохион байгуулагддаг

бол хувийн секторт ажиллагсдын хувьд амралтын өдөр ч ажиллах нь олонтаа байдагтай холбоотой байж болох юм. Иймд багийн ИНХ-д тус багт амьдарч буй бүхий л бүлгүүдийн иргэдийн оролцоог хангахуйц байдлаар зохион байгуулагдах нь зүйтэй байна. Хөдөөний алслагдмал багуудын хувьд хуралд иргэд оролцоход нилээд бэрхшээл учирдаг байна. Тодруулбал, хол амьдардаг учраас багийн хуралд оролцож чаддаггүй гэж хариулсан хүмүүс нь малчид байсан юм. Энэ нь цаг улирлын байдлаас хамаараад янз бүр байж болох талтай.

Орон нутгийн тулгамдсан асуудлуудыг бодитой хэлэлцэх, эрхмэдлийнхээ хүрээнд шийдвэр гаргадаг байх, шийдвэрийг Засаг дарга хариуцан гүйцэтгэх, хийсэн ажлаа олон нийтэд тайлагнадаг байх нь нэн түүрүүнд шаардлагатай байна. Мөн түүнчлэн багийн иргэдийн нийтийн хурлыг сайн зохион байгуулах, иргэдийн хэрэгцээг нэг бүрчлэн харгалзан үзэх нь чухал юм.


**1.2. Багийн иргэдийн нийтийн хурлын талаарх иргэдийн мэдлэгийн түвшин хангалтгүй байна**

Хэдийгээр Багийн ИНХ-ийн эрх мэдэл хязгаарлагдмал байгаа ч, иргэдийн оролцоо болон иргэдийн саналыг шийдвэр гаргахдаа тусгах түвшин өндөр байх боломжтой, засаг захиргааны үйл ажиллагааг хянаж болох засаг захиргааны анхдагч нэгж бол баг юм. Мөн түүнчлэн багийн ИНХ нь иргэдийн шууд оролцоо бүхий цорын ганц хурал билээ. Гэвч иргэд багийн ИНХ-ын эрх мэдлийн хүрээ, түүний зорилтуудыг мэдэх нь нэн шаардлагатай биш гэж үзэж байгаа нь энэ механизмын үр нөлөөг цаашид бууруулахад хүргэж болзошгүй юм. Судалгаанд оролцогсдын 60% нь багийн ИНХ-ын хууль ёсны эрх мэдлийн хүрээг мэдэхгүй байв.

Жишээ 5. Багийн хурлын үед л бид иргэдийн дуу хоолойг сонсож ямар асуудал тулгамдаад байгааг мэдэж зохих шийдвэр гаргадаг. Багийн эрх хэмжээ өчүүхэн л дээ. Ихэнх асуудал сумын захиргаанд хүрч байж шийдэгддэг. Өргөдөл хариу өгч авах, тодорхойлолт гаргах төдийгийн асуудал багт яригддаг. ....

(Архангай, Багийн засаг даргын ярианаас)

**График 7. Иргэд багийн ИНХ-д оролцдоггүй шалтгаан**



ТАН хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэний боловсрол олгох төсөл хэрэгжсэн багуудын ИНХ дахь иргэдийн ирц сайжирч, оролцооны хэлбэр, агуулга баяжиж байгааг иргэдтэй хийсэн бүлгийн ярилцлагын үед мэдрэгдсэн юм. Иргэдийн дунд ИНХ-д оролцох ач холбогдол, зорилгыг зөвөөр ухаарсан зан үйл, ойлголт хандлага бий болоогүй цагт багийн ИНХ одоогийн байдлаасаа өөрчлөгдөх боломжгүй юм. Иймээс иргэдийн шийдвэр гаргах явц дахь оролцоог нэмэгдүүлэхийн тулд иргэдийн иргэний боловсролд чанарын ахиц дэвшил гаргах хэрэгтэй байна. Харин иргэдийн шийдвэр гаргах явцад оролцох оролцоог нэмэгдүүлэхийн тулд «Иргэдийн иргэний боловсролыг дээшлүүлэх хэрэгтэй» гэж иргэдийн зүгээс хэлж байсан.

### 1.3. ИНХ болон хурлаас хэлэлцэх асуудлын талаар мэдээллийн хүртээмж муу байна

Багийнхаа ИНХ-д оролцдоггүй иргэдийн 39.3 хувь нь мэдээлэл байхгүй учраас оролцож чаддаггүй гэжээ. (График 7, Хүснэгт 2) Хачирхалтай нь аймгийн төвд амьдарч буй иргэд хөдөөний иргэдээс илүүтэй ингэж хариулсан байна. Энэ нь хөдөөний багийн Засаг дарга иргэдтэйгээ тулж ажиллах нь сайн байгааг илтгэнэ. Хөдөөний иргэд ч багийн ИНХ

**Хүснэгт 2. Мэдээлэл байхгүй учраас багийн хуралд оролцдоггүй**

Байршил	Хувь
Аймгийн төв	59,6 %
Сумдын төв	19,3 %
Хөдөө	21,1 %
Бүгд	100%

болон Засаг даргын талаар сумын болон аймгийн төвд амьдарч буй иргэдээс илүү мэдээлэлтэй байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байна. Хувийн секторт ажиллагсдын хувьд оролцож чаддаггүйгээ мэдээлэлгүй байдагтай холбон авч үзэх нь нийтлэг байв. Төрийн буюу төсвийн байгууллагын ажиллагсдын хувьд нутгийн удирдлагын байгууллагуудын талаархи мэдээлэл сайтай байгаа бөгөөд багийн оролцоо өндөр байна.

**Хүснэгт 3. Багийн ИНХ-ын талаархи мэдээлэл ба иргэдийн оролцоо**

	Байнга	Хааяа	Огт үгүй
Сайн мэдээлэлтэй	48,5%	17,2%	8,2%
Дунд зэрэг	38,2%	42,0%	27,4%
Хангалтгүй	13,2%	40,8%	64,4%
Бүгд	100%	100%	100%

Тухайн иргэнд нутгийн удирдлагын байгууллагуудын талаар хэр мэдээлэлтэй байгаа нь нэг талаас тухайн иргэний идэвх, оролцоо, ямар ажил эрхэлдэг зэргээс хамаардаг ч нөгөө талаас мэдээллийн түгээлт, хүртээмж нь тухайн иргэн идэвхтэй оролцоход

нөлөөлөх юм. Багийн нийтийн хурлын талаар мэдээлэлтэй иргэн хуралд тогтмол оролцож байхад харин мэдээлэл аваагүй иргэдийн хувьд багийн иргэдийн нийтийн хуралд огт оролцдоггүй болохыг доорхи хүснэгтээс харж болно. (Хүснэгт 3.) Нөгөө талаар багийн иргэдийн нийтийн хурлыг мэдээлэл тараах суваг болгож ашиглахын оронд иргэд тулгамдсан асуудлаа ярилцаж, зөвлөлдөх талбар байгаасай гэж багийн

хуралд байнга оролцогсод хэлж байлаа. Олон нийтийн дунд иргэдийн нийтийн хурлын хэлэлцэх асуудал, хэдийд хуралдах зэрэг мэдээллийн түгээлт нь хурлын ирцэд шууд нөлөөлдөг байна.

Мэдээлэл бол иргэний оролцооны суурь нөхцөл юм. Мэдээлэлгүй байгаа тохиолдолд оролцооны тухай ярих боломжгүй. Багийн Засаг даргын үйл ажиллагааны талаар иргэдийн 63,4 %, ИНХ-ын талаар 55,1 хувь нь ямар нэгэн мэдээлэл авдаг байна. (Хүснэгт 4.) Энэ нь нутгийн удирдлагын байгууллагуудын хувьд иргэдэд мэдээлэл хүрч буй хамгийн өндөр түвшин болж байна. Нутгийн удирдлагын түвшин буурах тусам иргэдийн энэ талаарх мэдээлэл бага зэрэг нэмэгдэж байна. Нутгийн удирдлагын анхдагч нэгж болох баг, ялангуяа Засаг дарга нар иргэдтэй

ойр ажилладаг нь иргэдэд илүү их мэдээллийг хүргэхэд нөлөөлдөг. Иргэд ИНХ-ыг бодвол багийн Засаг даргын талаар илүү их мэдээлэлтэй байна.

Хөдөөний алслагдмал багуудын хувьд хуралд иргэд оролцоход нилээд бэрхшээл учирдаг байна.

Тодруулбал, багийн хуралд оролцож чаддаггүй гэж хариулсан иргэд бүгд хөдөөгийн малчид байсан юм. Энэ нь цаг улирлын байдлаас хамаараад янз бүр байж болох талтай. Гэсэн хэдий ч тэд орон нутгийн Засаг дарга, багийн ИНХ-ын талаар сум, аймгийн иргэдтэй харьцуулахад илүү мэдэж байв.

**Хүснэгт 4. Багийн ИНХ, ЗД-ын талаар иргэд хэр мэдээлэлтэй байдаг вэ?**

	Багийн ИНХ	Хааяа ЗД
Мэдээлэлтэй	55,1	63,4
Мэдээлэлгүй	44,8	36,6
Бүгд	100%	100%

**Хүснэгт 5. Багийн удирдлагын талаархи иргэдийн мэдээлэл (оршин суугаа газраар, тухайн нутаг дахь мэдээлэлтэй иргэдийн хувь)**

	Аймгийн төв	Сумын төв	Хөдөө
Багийн ИНХ-ын талаар мэдээлэлтэй иргэд	52,5%	54,3%	60,8%
Багийн ЗД-ын талаар мэдээлэлтэй иргэд	59,3%	61,4%	73,2%

Судалгаанд оролцогчдын тал хувь нь “бусад хүмүүсийн ярианаас” мэдээлэл олж авч байгаа нь ам дамжсан яриа нутгийн удирдлагын талаар мэдээлэл дамжуулах нэгэн суваг болж байгааг харуулна. Тусгай хэвлэл мэдээллийн хэрэгсэл байхгүй багуудын хувьд мэдээлэл түгээж буй нэг суваг бол яах аргагүй ам дамжсан яриа. Гэхдээ хөдөө амьдарч байна уу, мэдээллийн арай олон суваг бүхий аймгийн төвд амьдарч байна уу гэдгээс үл хамаарч мэдээлэл авах нэгэн чухал суваг болж байгаа нь манай онцлог юм. Харамсалтай нь ам дамжсан ярианаас үнэн мэдээлэл олж авах магадлал тун бага байдгийг судлаачид нотолсон байдаг.



Жишээ 6. Хууль сурталчлах зорилгоор өрх бүрд дэвтэр нээж хот айлын дунд хууль сурталчлан бичсэн дэвтэр өгч дамжуулан уншуулдаг. Техник хэрэгсэл байхгүйгээс иргэд шардлагатай мэдээллээр хангахад хүндрэлтэй байна. Арга ядаад гараараа бичиж өрхүүдэд тараадаг

(Булган, Орхон, 3-р баг, Засаг дарга)

Баг бүр мэдээллийн самбар ажиллуулдаг. Энэхүү мэдээллийн самбарт ихэвчлэн иргэдэд эрх зүйн боловсрол олгох, цаг үеийн нийгэм эдийн засгийн үзүүлэлтүүд, зар мэдээ зэргийг тавьсан байдаг. Гэвч зар мэдээнээс бусад нь өөрчлөгддөггүй тул иргэдийн мэдээлэл авах суваг болж чадахгүй байна. Ер нь мэдээллийн самбар нь зөвхөн зорьж очсон эсвэл тэнд ажилладаг хүмүүст хүрдэг байна. Хөдөөний иргэд мэдээллийн самбараас мэдээлэл хүртэх боломж бага байдгийг харуулна. Техник хэрэгслийн хангамж муу, зардал мөнгөний хүндрэл нь багийн зүгээс мэдээлэл түгээхэд бэрхшээл үүсгэж байна. Нас, хүйс, боловсролын түвшингээс шалтгаалж мэдээлэл түгээлт харилцан адилгүй байна. Иймээс нийгмийн бүхий л бүлгүүд багийн ИНХ, Засаг даргын талаар мэдээлэл хүртэх бусад сувгийг олж ашиглах хэрэгтэй байна.

Нутгийн удирдлагын шийдвэр гаргагчид шийдвэр гаргахдаа иргэдийн санаа бодлыг тусгах байдал нь иргэдийн оролцоог хангаж байгаагийн нэгэн чухал үзүүлэлт болдогийн адил хэрэгжүүлсэн үйл ажиллагаагаа иргэдэд тайлагнах нь нэг талаас удирдлагын үйл хэргийг иргэдэд мэдээлэх, таниулах, сурталчилах шаардлагатай боловч нөгөө талаас иргэдэд хяналт тавих боломжийг олгох, мөн цаашдын шийдвэр гаргахад иргэдийн санал бодлыг хүлээн авч, тусгах явдлыг давхар агуулна.

Судалгаанаас харахад судалгаанд оролцогчдын 70 орчим хувь нь багийн Засаг дарга үйл ажиллагааны тайланг хэлэлцүүлдэг гэж хариулжээ. Судалгаанд оролцогчдын гуравны нэг нь багийн Засаг дарга үйл ажиллагааныхаа тайланг иргэдийн дунд хэлэлцүүлдэггүй гэж үзсэн байна. Энэ нь нутгийн удирдлагын бусад субъектүүдээс хамгийн өндөр үзүүлэлт байв. Иймээс нутгийн удирдлагын шатлал буурах тусам үйл ажиллагааныхаа тайланг хэлэлцүүлдэг гэсэн хариулт иргэдийн дунд нийтлэг байна. Энэ нь иргэд нутгийн удирдлагуудаас багийн Засаг даргын үйл ажиллагааг арай илүү мэдэж байгаа ч сум, аймгийн түвшинд энэ үзүүлэлт буурч байна гэсэн үг.

## 2. АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТҮВШИН ДЭХ ИРГЭДИЙН ОРОЛЦОО

Аймаг, сумын ИТХ-ын түвшинд шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоо хангалтгүй байна. Иргэдийн төлөөлөгчид нь сонгогчдынхоо санаа бодлыг гаргаж буй шийдвэртээ тусгах байдал туйлын хангалтгүй байна. Аймаг, сумын ИТХ-ын дэгд хуралдааны нээлттэй байдал тухайлбал иргэд, ИНБ-уудын төлөөлөгчдийг хуралдаанд оролцуулах, хуралдаанаар хэлэлцэх асуудал, гаргасан шийдвэрийг олон түмэнд мэдээлэх талаар тусгаагүй байна. Зөвхөн сонгуулийн өмнө л сонгогдогч, иргэдийн хооронд багахан харилцаа үүсдэгийг эс тооцвол, ИТХ-ын төлөөлөгчид иргэдийн хооронд баттай харилцаа тогтоогүй байна. Иргэдийн мэдлэгийн түвшин, ИТХ-д оролцох тохиромжтой механизм байхгүй байгаа нь ийм нөхцөл бий болоход нөлөөлж байна. Дээрх бүх нөхцөл байдлууд иргэдийн оролцоонд сөргөөр нөлөөлж байна.

Аймаг, сумын ИТХ нь дээд шатныхаа хурал, бусад байгууллагын эрх хэмжээнд хамаарахаас бусад нутаг дэвсгэртэй холбоотой асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх эрхтэй бөгөөд дараах үндсэн асуудлыг өөрийн эрхийн дагуу шийдвэрлэдэг. Үүнд:

1. Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдал, хэтийн төлөв, төсөв, санхүүгийн үйл ажиллагаа, түүний гүйцэтгэлийн тайлан,
2. Засаг даргыг томилуулахаар нэр дэвшүүлэх, чөлөөлүүлэх, огцруулахаар дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайдад санал болгох,
3. Шаардлагатай гэж үзвэл Засаг даргын ажлын тайланг хэлэлцэж үйл ажиллагаанд нь дүгнэлт өгөх

Хурлын Тэргүүлэгчид Хурлын чөлөөт цагт түүний онцгой эрхэд хамааруулснаас бусад бүрэн эрхийг өөрөө бие даан эдэлдэг. Үүнд:

1. Хурлын хуралдааныг товлон зарлах, түүний бэлтгэл хангах, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон санал, шийдвэр боловсруулах,
2. Хурлын шийдвэрийн биелэлтийг хянан шалгах,
3. Иргэн, аж ахуйн нэгж, төр, олон нийтийн байгууллагаас тавьсан санал, өргөдөл, гомдол шийдвэрлэх,
4. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын болон Хурлын төлөөлөгчдийн сонгууль явуулахад туслах
5. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр хуулийн төсөл, төр, нийгмийн амьдралын чуха асуудал ард нийтээр хэлэлцүүлэх, санал асуулга явуулах ажлыг нутаг дэвсгэртээ зохион байгуулах,
6. Шаардлагатай гэж үзвэл нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын асуудал хэлэлцэж шийдвэрлэх,
7. Төрийн дээд шагналд тодорхойлох талаар уламжлах.

## 2.1. Аймаг, сумын ИТХ-ын түвшинд иргэдийн оролцоог хангах эрх зүйн заалт хангалтгүй байна

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуульд ИТХ-ын хурлын төлөөлөгч, Тэргүүлэгчид, тухайн нэгжийн Засаг дарга хуралд хэлэлцүүлэхээр асуудал санаачлан оруулах эрхтэй бөгөөд төр, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж, тухайн шатны хуралд, сум, дүүрэг, баг, хорооны хурал зохих дээд шатны хуралд асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно хэмээн заасан байдаг. Өөрөөр хэлбэл иргэд ИТХ-д асуудал оруулахыг хүсвэл дээрх эрх бүхий субъектуудээр дамжуулах шаардлагатай гэсэн үг. Дээрх хуулийн энэ заалт нь зөвхөн 11 аймгын л ИТХ-ын хуралдааны дэгд тусгагдсан байгаа нь иргэдийн оролцоонд ямар ач холбогдол өгч буйн тусгал гэж хэлж болохоор байна<sup>8</sup>.

Иргэдийн хувьд хурлын төлөөлөгчид санал, өргөдөл, гомдлоо уламжлах, хурлаас зохион байгуулсан олон нийтийн хурал, бусад арга хэмжээнд оролцох, хурлаас зохион байгуулсан санал асуулгад оролцох, хурлаас холбогдох мэдээлэл гаргуулж авах, иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгжээр дамжуулан санал, гомдлоо тавих, шийдвэрлүүлэх, хуралдаанд урилгаар ажиглах эрхтэй оролцох (Булган, Хэнтий аймагт) зэргээр ИТХ-ын үйл ажиллагаанд оролцох боломж эрх зүйн хувьд зохицуулагдсан байна.

ИТХ-ын хуралд иргэдийг оролцуулах талаар аймгуудын хурлын дэгд дараах байдлаар тусгажээ:

- ❖ Булган аймгийн ИТХ-ын дэгийн 7-р зүйл, Хэнтий аймгийн ИТХ-ын дэгийн 2.9-д тухайн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан «Монгол Улсын Их Хурлын гишүүд, төр, нам, аж ахуй, хоршоолол, олон нийтийн байгууллагын ажилтан, хэвлэл мэдээллийн албаны хүмүүс, иргэдийг урилгаар оролцуулах асуудлыг хурлын тэргүүлэгчдээс зохион байгуулж болно. Урилгаар оролцогсод нь хуралдааны дотоод журам, дэгийг биелүүлэх үүрэгтэй» гэж заажээ. Харин Архангай аймгийн хурлын дэгд иргэдийг оролцуулах талаарх ямар нэгэн зүйл заалт алга байна.
- ❖ Сумдын тухайд мөн л 9 сумаас зөвхөн Булган аймгийн Булган сумын ИТХ-ын хуралдааны дэгд «Тухайн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдох албан тушаалтан болон иргэдийг урилгаар оролцуулах асуудлыг хурлын тэргүүлэгчид шийдвэрлэнэ» гэж заасан байна<sup>9</sup>.

<sup>8</sup>Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нээлттэй байдал-иргэдийн оролцоо: судалгааны тайлан. УБ:2005

<sup>9</sup>Булган аймгийн Булган сумын ИТХ-ын хуралдааны дэг. 2005.12.27нд батлагдсан.



Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуулийн дагуу аймаг, сумын ИТХ-ын тэргүүлэгчид, түүний дарга нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр хуулийн төсөл, төр, нийгмийн амьдралын чухал асуудал ард нийтээр хэлэлцүүлэх, санал асуулга явуулах ажлыг нутаг дэвсгэртээ зохион байгуулах бүрэн эрхтэй байдаг.

- ❖ Дээрх эрх хэмжээний хүрээнд «Баримт бичгийн төслийг иргэдэд сурталчилж тэдний саналыг өргөнөөр авах зорилгоор хурал цуглаан зохион байгуулах, хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төслийг орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтээр хэлэлцүүлж болно» гэсэн заалт Булган аймгийн ИТХ-ын дэгд байна<sup>10</sup>. Мөн энд хуралдаанаар «Хэлэлцэх асуудлыг сайтар бэлтгэх, судалгаа дүгнэлт гаргах, шийдвэрийн төслийг урьдчилан боловсруулж нийт иргэдээр хэлэлцүүлэх зорилгоор хуралдаанд бэлтгэх ажлын хэсгийг хурлын тэргүүлэгчдээс байгуулан ажиллуулж болно» гэж заасан нь бусад аймгийн хувьд үнэхээр дэвшилттэй зохицуулалт болжээ. Мөн харьяа нутаг дэвсгэр дэх нам, олон нийт, шашны байгууллагуудтай харилцахыг ИТХ-ын даргын бүрэн эрхэд хуулиар хамааруулсан байна. Мөн түүнчлэн тус аймгийн ИТХ “Нутгийн удирдлагын 2005-2005 оны үйл ажиллагааны чиглэл, хөтөлбөр”-т шийдвэр гаргахад иргэдийн оролцох оролцоог сайжруулах, мэдээлэл авах, иргэд санаа бодлоо илэрхийлэх, хууль шийдвэр сурталчлахад ИТХ-ын төлөөлөгчдийн үүргийг өндөржүүлж ажиллах, төлөөлөгчдийн сонгогчидтойгоо ажиллах боломжийг сайжруулах тухай тусгажээ.
- ❖ ИТХ-ыг нээлттэй эсвэл хаалттай явуулах талаар судалгаанд багтсан бүх аймаг, сумдын хурлын дэгд тодорхой зүйл, заалт байхгүй байна. «Хуралдааны явцад гарсан санал, үзэл бодлын зөрүү, төлөөлөгчдийн ярианы нууцыг хуралдаанд оролцогчид бүрэн хадгалах үүрэгтэй» гэсэн заалт Булган аймгийн Орхон сумын ИТХ-ын анхдугаар хуралдааны дэгд байгаа нь хаалттай байдлыг нь харуулж байна.

Одоогийн мөрдөгдөж байгаа ихэнх дэгүүдэд ил тод байдлыг нэмэгдүүлэх, шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн оролцоог дэмжих нь оролцооны механизмуудыг бий болгох чухал алхам юм гэсэн заалтууд байдаг. Уг механизмуудыг үр дүнтэй болгохын тулд өөрсдийн эрхийг хэрэгжүүлэх чин эрмэлзэлтэй, мэдлэгтэй иргэд, хэрэгжүүлэх арга замуудыг бий болгох нь чухал байна. Ийнхүү судалгаа явагдсан аймаг, сумдын ИТХ-ын хуралдааны дэгүүдээс харахад шийдвэр гаргах үйл явцад иргэд оролцох боломжийг хангалттай түвшинд олгож чадахгүй байна. Ер нь иргэдэд нээлттэй байх, шийдвэр гаргахдаа болон шийдвэрийн хэрэгжүүлэлтийн талаар иргэдтэй зөвлөлдөх, иргэдийн оролцоог хангах

<sup>10</sup>Булган аймгийн ИТХ-ын хуралдааны дэг. 2000.10.15нд батлагдсан



талаар тун хангалтгүй байна. Түүнчлэн иргэдийн төлөөлөгч ба иргэн хоорондын зөвлөлдөх, мэдээллээр хангах, тайлагнах зэргээр эргэх холбоотой ажиллах тухай тодорхой заалт байхгүй байна.


Дэгд тусгагдаагүй ч зарим сумын хувьд ИТХ-ын хуралдааныг иргэдийн өргөн төлөөлөлтэй өргөтгөсөн байдлаар зохион байгуулсан шинэлэг алхмууд шийдвэр гаргагчдын санаачлагаар хийгдсэн явдал байгаа нь иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд зөвхөн эрх зүйн зохицуулалтаар хязгаарлагдах ёсгүйг илтгэж байна<sup>11</sup>.

## 2.2. ИТХ-ын төлөөлөгч ба сонгогчдын хоорондын харилцаа холбоо сул байна.

Иргэдийн төлөөлөгч бол орон нутгийн иргэдийн төлөөлөн болон сонгогдсон, иргэдийн эрх ашиг, хэрэгцээ, саналыг судлан хурлаар шийдүүлэх эрх үүрэг бүхий төрийн түшээ билээ. Тэд шууд сонгуулийн үндсэн дээр харьяа тойргийн иргэдээс 4 жилийн хугацаатай сонгогддог. Улс төрийн намуудаас болон иргэд бие даан нэрээ дэвшүүлж сонгуульд өрсөлддөг. Төлөөлөгчид сонгогдсон тойргийнхоо болон аймаг, сумынхаа нийтлэг эрх ашгийг илэрхийлж, нутгийн өөрийн удирдлагыг гардан хэрэгжүүлэгчид байх үүрэгтэй. Төлөөлөгч нь хурлын эрх хэмжээний асуудал хэлэлцэхэд таслах эрхтэй оролцох, хуралд тодорхой асуудал хэлэлцүүлэхээр санаачлах, хурлаас байгуулсан байгууллага, сонгосон буюу томилсон албан тушаалтны илтгэл, сонсгол хэлэлцүүлэх санал гаргах, хууль тогтоомж, хурлын шийдвэрийг иргэдэд тайлбарлан таниулах бүрэн эрх эдэлдэг.

Иргэдийг төлөөлөн, тэдний эрх ашгийг илэрхийлж, бодлого тодорхойлох эрхтэй төлөөлөгчид иргэдтэй ойртож ажиллах, тэдний санаа бодлыг сонсох, бодлого шийдвэрт тусгах байдал тун хангалтгүй байна. (График 8)

**График 8.** Та хурлын төлөөлөгчтэй хэр тогтмол уулздаг вэ?



<sup>11</sup>Манай Цэнхэр сумын ИТХ иргэдтэйгээ хоёр удаа нийлж өргөтгөсөн хуралдаан хийсэн. Уг хурлаар сумын ард иргэдээс байгаль хамгаалах, хуурай хог хаягдлаас салах талаар нилээд ярьсан. Овоо ч хэрэгжсэн. Ингээд хамтраад ажиллаад байвал үр дүн нь уг нь сайн гарах юм байна гэж бодогдсон. (Архангай аймгийн, Цэнхэр сумын иргэдтэй хийсэн ярилцлагаас)

Иргэдийн олонхинь аймаг сумын хурлын төлөөлөгчидтэй огт уулзалдаггүй гэж хариулсан байна. Ялангуяа аймгийн хурлын төлөөлөгчидтэй иргэдийн 29.7 хувь нь уулздаг байна. Иргэд өөрсдийнхөө сонгосон төлөөлөгчтэйгээ уулзаж санал хүсэлтээ илэрхийлдэггүй учраас тэдний санаа бодол, хэрэгцээ хурлаар төдийлэн яригддаггүй байна. Иргэд ч ингэж үзсэн байна. (Жишээ 7.)


Жишээ 7. Иргэдийнхээ төлөөлөгчөөр дамжуулан санал бодлоо хэлж яримаар байдаг боловч төлөөлөгч маань бидэнтэй ирж уулздаггүй. Бидэнд явж очоод ярих зав чөлөө ч олддоггүй. Газрын талаар санал гомдол тавьж байсан боловч сумын ЗД, түүний тамгын газар иргэдийн санал бодлыг хүлээж авдаггүй.

(Архангай, Цэнхэр сумын малчидтай хийсэн ярилцлагаас)

Судалгаанд оролцогчдын 20 орчим хувь нь өөрийн тойргоос сонгогдсон сумын ИТХ-ын төлөөлөгчөө, гуравны нэг орчим нь (хамгийн бага үзүүлэлт) өөрийн тойргоос сонгогдсон аймгийн ИТХ-н төлөөлөгчөө танихгүй байв. Аймгийн төвд оршин суугчдын олонхи нь бусад газрын оршин суугчдаас илүү сумын ИТХ-ын төлөөлөгчөө танихгүй байна. Гэтэл аймгийн Засаг даргаа таньдаггүй иргэд 15 хувийг (Засаг дарга нараас хамгийн бага хувьтай нь) эзэлж байна.

Иргэдийн 92.0 хувь нь аймгийн, 84.0 хувь нь сумын ИТХ-д өргөдөл, гомдол саналаа огт илэрхийлж байгаагүй байна (График 9). ИТХ-ын үйл ажиллагаанд оролцох боломжуудаас иргэдийн олонхи нь (3-ны 2 нь) өргөдөл, гомдол, саналаа уламжлах тухай мэдэж байсан. Нутгийн удирдлагын байгууллагуудад өргөдөл, гомдол, саналаа илэрхийлэх байдал нь иргэдийн наснаас хамаарч нэмэгддэг нь асуулгын дүнгээс харагдаж байна. Харин хүйсийн хувьд төдийлөн ялгаагүй бөгөөд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийг бодвол нутгийн удирдлагын байгууллагуудад өргөдөл, гомдол, саналаа илэрхийлэхдээ арай илүү хувьтай байв.

**График 9.** Та дараах байгууллагуудад өргөдөл, гомдол, саналаа илэрхийлж байсан уу?



Иргэдийн төлөөлөгч болон иргэдийн хооронд тун бага харилцаа байдгийг дээрх дүн харуулж байна. Хэдийгээр 2 жилийн өмнө буюу 2004 онд орон нутгийн ээлжит сонгууль болсон ч маш олон иргэд өөрийн орон нутгаас буюу тойргоос сонгогдсон аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчөө танихгүй гэсэн нь төлөөлөгчид иргэдтэй ойртож ажиллахгүй, тэднийг жинхэнэ утгаар төлөөлж байгаа эсэхэд эргэлзэхэд хүргэж байна. (Жишээ 8.)

Жишээ 8. Одоогоор ямар хүнд саналаа өгснөө мэдэхгүй хүмүүс олон байдаг. Бараг л гоё нэртэй хүний нэрийг нь дугуйлдаг гэсэн хошин яриа байдаг нь үнэний ортой байх.


(Архангай, Цахир сумын иргэдийн ярилцлагаас)

Иргэд ИТХ-д хандахаас илүү багийн Засаг дарга, хуралд хандах нь илүүтэй байна. Энэ нь нэг талаас иргэдийн ямар асуудал, зорилгоор хандаж буйгаас шалтгаалах боловч нөгөө талаас хуралд итгэх иргэдийн итгэлтэй холбоотой байна. Өргөдөл, гомдол, саналаа илэрхийлж байсан нийт иргэдийн олонхи нь ямар нэгэн баримт бичгийн лавлагаа авах эсвэл тусламж дэмжлэг хүсэх зорилготой байжээ. Ялангуяа багийн Засаг дарга, сумын Засаг даргын Тамгын газарт энэ асуудлаар илүүтэй ханддаг байна. Энэ нь иргэдийн хаана амьдарч буйгаас төдийлэн хамаарахгүй байна. Өөрөөр хэлбэл аймгийн төвд амьдарч буй иргэд хөдөө багийнхны адил багийн Засаг даргатай илүү тогтмол харилцдаг байна. Харин аймгийн төвд амьдарч буй иргэд сумынхаа ИТХ, ЗДТГ-т хандахаас илүү багийн болон аймгийн Засаг даргад ханддаг байна. Бусад байгууллагуудад иргэд төдийлэн ханддаггүй, ихэвчлэн ЗДТГ-т очдог байна. Харин төрийн албан хаагчдын тухай гомдол, саналаа илэрхийлэх, хууль эрх зүйн мэдээлэл авах, хөнгөлөлт чөлөөлөлт хүсэх, төрийн байгууллагын ажлын тайлангийн талаар иргэд төдийлэн санал гомдол гаргадаггүй гэж дүгнэж болохоор байна<sup>12</sup>.

Аймгийн ИТХ болон ЗДТГ-т иргэд өргөдөл, гомдол, саналаа гаргах нь газар нутгийн хол ойроос тодорхой хэмжээнд хамаардаг боловч аймгийн ИТХ болон ЗДТГ-т өргөдөл, гомдол, саналаа илэрхийлэх түвшин нь аймгийн төв, сум, хөдөөнөөс төдийлэн ялгаагүй байна. Өөрөөр хэлбэл иргэд нутгийн удирдлагын анхан шатны нэгж болох багийн Засаг дарга, хурал, сумын Засаг даргад хандаж асуудлаа шийдвэрлүүлэх, дээд шатны байгууллагад уламжлуулах нь нийтлэг байдаг байна. Энэ нь график 10-аас тодорхой харагдаж байна.

<sup>12</sup>Дээрх асуултад иргэдийн 10-15 хувь нь «тийм» буюу ханддаг гэж хариулсан байна.

**График 10.** Тө өөрийн өргөдөл, гомдол, саналаа ихэвчлэн хэнд хандаж гаргадаг вэ?




Судалгаанд оролцогч иргэдийн 24.0 хувь нь бидний санал сумын ИТХ-н шийдвэрт, 15.5 хувь нь аймгийн ИТХ-ын шийдвэрт тусгагддаг гэж хариулсан нь тухайн түвшний Засаг дарга нарын шийдвэрт тусгагддаг гэж хариулснаас доогуур хувьтай байгаа нь иргэн ба ИТХ-ын хоорондын харилцаа ямар түвшинд байгааг илэрхийлж байна. Иргэд өөрийн тойргийн төлөөлөгчөөрөө дамжуулан аль ч шатны ИТХ-ын шийдвэрт нөлөөлж болно. Гэвч ИТХ-ын төлөөлөгч ба иргэн хоорондын харилцаа холбоо тааруу байна (өмнө дурдсан). Гэхдээ ганц нэг сумдын ИТХ аливаа шийдвэр гаргахдаа иргэдтэйгээ зөвлөлдөх арга хувилбаруудыг нэвтрүүлж эхлээд байгаа нь сайшаалтай. (Жишээ 9.)

Жишээ 9. Сумын ИТХ иргэдтэйгээ 2 удаа нийлж хуралдсан. Уг хурлаар сумын ард иргэдээс байгаль хамгаалах талаар, хуурай хог хаягдлаас салах талаар нилээд ярьсан. Овоо ч хэрэгжсэн. Ингээд хамтраад ажиллаад байвал үр дүн сайн гаргах юм байна гэж бодогдсон.

(Архангай, Цэнхэр сум, малчидтай хийсэн ярилцлагаас)

Аль ч аймгаас судалгаанд оролцсон иргэдийн хувьд Аймгийн ИТХ нь иргэдийн саналыг хамгийн бага тусгадаг гэж үзэх хандлага нийтлэг байна. ИТХ хэрэгжүүлсэн үйл ажиллагааныхаа тайланг иргэдэд танилцуулж хэлэлцүүлэх нь ИТХ, иргэдийн хоорондын харилцааг харуулдаг. Судалгаанд оролцогчдын 50 орчим хувь нь Аймгийн болон сумын ИТХ-ыг тайлангаа хэлэлцүүлдэг гэж үзсэн байна. 10 хүний нэг нь үйл ажиллагааныхаа тайланг байнга хэлэлцүүлдэг гэж үзсэн нь нутгийн удирдлагын зүгээс тайлангаа хэлэлцүүлэх явдал тун хангалтгүй байгааг харуулна.

**График 11.** ИТХ шийдвэр гаргахдаа иргэдийн саналыг тусгадаг уу?



Ийнхүү орон нутгийн иргэдээс төлөөлөн сонгогдсон ИТХ-ын төлөөлөгч нь иргэдийн эрх ашиг, хэрэгцээ, саналыг судлан, бодлого шийдвэрт тусгах эрх үүргээ тааруухан хэрэгжүүлж байна. Төлөөлөгчид сонгогдсон тойргийнхоо иргэдтэй уулзаж, зөвлөлдөж, тэдний санал бодлыг сонсож, ИТХ-д оруулах байдлыг хангалтгүй гэж үзэж байна. Энэ нь иргэд ИТХ-ын төлөөлөгчөөрөө дамжуулан эрх ашгаа илэрхийлж, ашиг сонирхол, хэрэгцээгээ орон нутгийн бодлогод тусгах мэдлэг туршлага тааруухан байгаатай холбоотой.

### 2.3. Сум, аймгийн ИТХ-ын зорилго, зорилтуудыг иргэд мэдэхгүй байна.

Иргэдийн ИТХ-ын шийдвэр гаргах үйл явцад оролцох боломж, төлөөлөгчтэйгээ хамтарч ажиллах талаар хангалтгүй мэдлэгтэй байна. ИТХ-ын хэлэлцэх асуудлын талаар иргэн санал гаргах, хэлэлцэх асуудлын талаар мэдээлэл авах боломжтой гэдгээ иргэд төдийлөн сайн мэдэхгүй байна. Энэ нь иргэд аль ч шатны ИТХ-ын талаархи мэдээлэл багатай байгаатай холбоотой. ИТХ-д ажиглах эрхтэйгээр иргэд оролцох, ТББ урилгаар оролцох боломжийн талаар цөөхөн хүн мэддэг байна. (дөнгөж 30 гаруй %)

Жишээ 10. Бид эрх үүргээ мэдэхгүй, шийдвэр гаргах явцад оролцох арга мэддэггүйгээс бас болж байна.

(Булган, Орхон сумын иргэдтэй хийсэн бүлгийн ярилцлагаас)

Иргэдийн 27.5 хувь хэрхэн оролцох талаарх мэдээлэл, мэдлэг дутмаг учраас ИТХ-д хандаж байгаагүй гэсэн байна. Мөн иргэдийн 50-60 хувь нь ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэх асуудал оруулах, мэдээлэл авах арга зам, урилгаар оролцох тухайд ямар ч ойлголтгүй байна. Ийнхүү нутгийн удирдлагын байгууллагуудад өргөдөл, гомдол, саналаа илэрхийлж байгаагүйн шалтгааныг иргэд оролцох ёстойгоо сайн

мэдэхгүй, зав муутай байдагтай холбон тайлбарлажээ. Энэ нь хаана амьдарч байгаагаас бага зэрэг хамаарч, зөв ойлголттой иргэдийн тоогоороо аймгийн төвийн оршин суугчид хөдөөгийнхнийг бодвол тэргүүлж байна. Боловсролын түвшин, нас, хүйс зэрэг хүн ам зүйн бүлгүүд мэдлэгийн хувьд ач холбогдол өгөхүйц ялгаа илэрсэнгүй.


Жишээ 11. Оролцож болох үгүйгээ мэдэхгүй яаж оролцох ухаанаа олохгүй байгаадаа гол нь байгаа юм. Иргэд нэгдэж чадахгүй байна. Хамтран ажиллах, мэдлэг, туршлага дутаад байна.

(Архангай, Цэнхэр, иргэдтэй хийсэн бүлгийн ярилцлагаас)

Бүлгийн ярилцлага болон ганцаарчилсан ярилцлагын мэдээллээс харахад сум, аймгийн ИТХ-д тухайн асуудлыг хариуцан ажилладаг төрийн байгууллага, хувийн хэвшлийнхний удирдлагыг хуралдаанд урилгаар оролцуулдаг болох нь харагдаж байв. Харин хүүхэд, эмэгтэйчүүд, залуучууд, ахмадуудтай холбоотой асуудал хэлэлцэх тохиолдолд л холбогдох ТББ-аас урилгаар хүн оролцуулах явдал түгээмэл байдаг байна. Харин хэн нэгнийг оролцуулсан тохиолдол бараг үгүй бөгөөд энэ нь нэг талаас шийдвэр гаргагчдын зүгээс иргэдийг оролцуулах боломжийг бүрдүүлсэн байдал нөгөө талаас иргэдийн өөрсдийнх нь мэдлэг боловсролоос хамаарч байна.

Дээр дурдсанаар ИТХ-ын зүгээс өөрсдийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажилладаггүй, иргэдэд мэдээлэл түгээх талаар сайн анхаардаггүй байна. Түүнчлэн дээрх хүснэгтээс харахад судалгаанд оролцогчдын тал гаруй хувь нь сумын ИТХ, 40 гаруй хувь нь аймгийн ИТХ-ын талаар мэдээлэлтэй байгаа нь мэдээлэл түгээлт, хүртээмж тааруухан байгааг харуулна. (График 12.)

График 12. Иргэдийн ИТХ-д оролцох боломжууд



Мөн аймаг, сумдын ИТХ-ууд мэдээллийг хязгаарлагдмал хүрээнд буюу нутгийн бүхий л иргэдэд хүрэхүйц байдлаар түгээж чадахгүй, түгээж буй арга хэрэгсэл нь тохирохгүй байна гэсэн үг. Гэхдээ аймгуудын ИТХ-ын зүгээс мэдээллийн нээлттэй танхим нээж ажиллуулах, мэдээлэл түгээх талаар тодорхой санаачлагууд хэрэгжиж эхэлж байна. Гэвч бодит байдал дээр хэр зэрэг үр дүнтэй байгаа нь асуудалтай байна. Зарим ИТХ -ууд орон нутгийн сонинтой хамтран ажиллаж хуралдааны шийдвэрийг сонин хэвлэлд гаргадаг байна.

ИТХ-ын төлөөлөгч ба иргэдийн хооронд харилцаа төлөвшөөгүй, иргэдийн эрх ашиг, санаа бодолд тулгуурлан орон нутгийн шийдвэр, бодлого тодорхойлогдож чадахгүй байна. Энэ нь ИТХ-ын талаар болон түүнд оролцох арга замыг хуралдааны дэгд тусгаагүй, иргэдийн ИТХ-ын талаархи мэдлэг, мэдээлэл тааруу, иргэдийн ИТХ-д хандахаасаа илүү Засаг даргад хандах, иргэдийн саналаа нэгтгэх, хамтран ажиллах

дадлага туршлага тааруу байгаа нь иргэдийн оролцоо сул байхад нөлөөлж байна. Засаг дарга нар орон нутагт тулгамдсан асуудлыг иргэдтэй хэлэлцэх, хуулиар олгогдсон эрх мэдлийнхээ хүрээнд шийдвэр гаргах, шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, хийсэн ажлаа тайлагнадаг байх шаардлагатай байна.

**Хүснэгт 6. Сум, аймгийн ИТХ-ын талаар иргэд хэр мэдээлэлтэй байдаг вэ?**

	Сумын ИТХ	Аймгийн ИТХ
Сайн мэдээлэлтэй	17,5	12,1
Дунд зэрэг	34,8	28,4
Хангалтгүй	47,7	59,5
Бүгд	100%	100%



### 3. СУМ, АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА НАР БОЛОН ИРГЭДИЙН ХООРОНДЫН ХАРИЛЦАА

Энэ судалгаагаар сум, аймгийн Засаг даргын түвшин дэх шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоо ямар байгааг судлахыг зориогүй. Гэвч судалгааны явцад зарим баримт мэдээлэл цугларч, ажиглалт хийгдсэн нь орон нутгийн засаг дарга нарт сонирхолтой, хэрэгтэй байж болох юм. Энэ түвшин дэх иргэдийн оролцоог нарийн мэдэх шаардлагатай гэж цэвэр өөр судалгаа хийх хэрэгтэй. Засаг дарга нь үйл ажиллагаа явуулах эрх цэргийнхээ дагуу нийгэм, эдийн засгийн байдалд тулгуурлан иргэдийн оролцоо, санаа бодлыг тусган, мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх замаар явуулна. Гэвч үйл ажиллагаагаа эргэж тайлагнах, энэ талаар мэдээлэл өгөх механизм бий болоогүй байгаа нь иргэдийн оролцоог буурахад хүргэдэг байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн эрх хэмжээг Үндсэн хууль болон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар зохицуулж өгсөн байдаг. Засаг дарга нь тухайн нэгжийн хөгжлийн төлөвлөлтийг удирдан зохион байгуулах, төсөв санхүү, татварын бодлогыг хэрэгжүүлэх, хүн амд ерөнхий боловсрол олгох, эрүүл мэндийг сахин хамгаалах, соёл урлаг, шинжлэх ухааныг хөгжүүлэх, байгаль хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх, хууль ёс, дэг журмыг сахиулах, орон нутгийн дэд бүтцийг сайжруулах зэрэг бараг бүх салбар чиглэлээр тодорхой үүрэг хүлээж, эрх эдэлж байна. Өөрөөр хэлбэл төрийн төвлөрсөн удирдлагыг орон нутагт хэрэгжүүлэгч гол албан тушаалтан билээ.

Засаг даргын шийдвэр гаргах үйл явцад иргэд оролцох, нөлөөлөх явдлыг иргэдийн мэдээлэл авах боломж, засаг дарга шийдвэр гаргахаас өмнө орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт, бодлогын талаар иргэдтэй зөвлөлдөх, санаа бодлыг судлах, хийсэн ажлаа иргэдэд тайлагнаж, хэлэлцүүлэх, удирдлагын ил тод байдлыг хангаж буйгаар тодорхойлж үзэх боломжтой.

Нутгийн захиргааны байгууллагын хувьд Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн дагуу төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдлыг ханган, төр иргэдийн холбоог сайжруулах зорилтыг аймгийн засаг дарга нар 2004-2006 үйл ажиллагааны хөтөлбөртөө тусгажээ. Үүнд аймгийн төр, захиргааны байгууллагын удирдлага орон нутгийн хэвлэл, радио телевиз, мэдээллийн утсаар дамжуулан тулгамдсан асуудлаар иргэдтэй санал солилцож, тэдэнд хариулт өгдөг тогтолцоо бүрдүүлнэ<sup>13</sup>, иргэдийн санал хүсэлт, өргөдөлд тавьсан асуудлыг бодитойгоор хэрэгжүүлэн, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, төр иргэдийн холбоог бэхжүүлэх ажлыг өргөтгөнө<sup>14</sup>, иргэд сум орон

<sup>13</sup>Хэнтий аймгийн Засаг даргын 2004-2008 онд хэрэгжүүлэх үйл ажиллагшааны мөрийн хөтөлбөр. Өндөрхаан: 2004.

<sup>14</sup>Булган аймгийн Засаг даргын 2005-2008 оны үйл ажиллагааны хөтөлбөр. 2004. Нутгийн удирдлагын 2005-2008 оны үйл ажиллагааны чиглэл, хөтөлбөр. Булган: 2005

нутгийн ашиг сонирхол хөндөгдөн байгаа тал болон иргэдийн санал бодолд тулгуурлан асуудлыг шийдвэрлэнэ<sup>15</sup> гэсэн зорилтууд дэвшүүлж энэ хүрээнд зарим ажлууд хийгдэж байгаа юм байна. Түүнчлэн зарим сумдын ИТХ иргэдийг оролцуулсан өргөтгөсөн хурал зохион байгуулах, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч хариу өгөх ажилтан ажиллуулах, саналын хайрцаг ажиллуулах санаачлага гарч байна<sup>16</sup>.

Хэнтий аймагт аймгийн ЗДТГ-аас иргэдтэй санал солилцож, тэдэнд хариулт өгдөг 23303 гэдэг мэдээллийн утас ажиллуулж эхлээд байна. Ийм ажил Булган аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байна. Мөн Булган аймагт нутгийн удирдлагын байгууллагын үйл ажиллагааг иргэдэд үр өгөөжтэй мэдээлдэг сум шалгаруулдаг болзол гарган өнгөрсөн жилээс хэрэгжүүлж байгаа юм байна. Түүнчлэн зарим сумдын ИТХ иргэдийг оролцуулсан өргөтгөсөн хурал зохион байгуулах, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч хариу өгөх ажилтан ажиллуулах, саналын хайрцаг ажиллуулах санаачлага гарч байна .

Судалгааны дүнгээс харвал иргэдийн зүгээс хамгийн ихээр ханддаг нутгийн удирдлагын субъектууд нь Засаг дарга нар байна. Иргэд бүх шатны ИТХ-тай харилцахаас илүү ЗД нартай харилцдаг байна гэж үзэх үндэс байна. Учир нь судалгаанд оролцогчдын 93,8 хувь нь сумын Засаг даргаа, 84,8 хувь нь аймгийн Засаг даргаа таньдаг байна. Ер нь судалгааны дүнгээс харвал иргэдийн зүгээс хамгийн ихээр ханддаг нутгийн удирдлагын субъектээр нэгд багийн ЗД, хоёрт сумын ЗД, гуравт, аймгийн ЗД болох нь тодорч байгаа билээ.

Засаг дарга нар нь иргэдийн өдөр тутмын амьдралтай илүү ойр ажилладаг нь үүнтэй холбоотой билээ. Хүмүүсийн Засаг даргын тамгын газар хандан санал хүсэлтээ тавих нь тэдний нас, боловсролын түвшинтэй холбоотой байдаг байна. Тухайлбал, залуу хүмүүс засаг дарга нарт хандан санал хүсэлт тавих нь бага (23,3% нь сумын Засаг даргад, 3,3% нь аймгийн Засаг даргад хандаж байжээ) байдаг. Харин бүрэн дунд боловсролтой хүмүүс бакалаврын зэрэгтэй хүмүүсийг бодвол Засаг даргад илүү их ханддаг байна.

### 3.1. Иргэдэд мэдээлэл дутмаг байна


Хэдийгээр иргэд сум, аймгийн Засаг дарга нарыг сайн таньдаг ч тэдний иргэдийг мэдээллээр хангаж буй байдал, үйл ажиллагааны ил тод байдал хангалтгүй байна. Учир нь иргэдийн тал гаруй хувь нь аймгийн Засаг даргын талаар мэдээлэлтэй байна (График 13). Мөн л орон зайн хүчин зүйлс нөлөөлж хөдөөнийхөн болон сумын төвийнхөн аймгийн ЗД-ын талаархи мэдээлэл муутай байна. Энэ нь мөн л мэдээллийг

<sup>15</sup>Архангай аймгийн Засаг дарга болон сумын засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт. 2006. Цэцэрлэг.

<sup>16</sup>Архангай аймгийн ИТХ-ын ажлын албанд ийм ажилтан ажиллуулж байгаа тухай хурлын дарга өгүүлэв. 2006.07.10. Мөн Архангай аймгийн Цэнхэр сумын ИТХ иргэдийг оролцуулсан хурал зохион байгуулсан байна (Сумын малчидтай хийсэн ярилцлагаас). Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын ЗДТГ-ын хэлтсийн даргын яриа.

түгээж буй хүрээ явцуу, түгээж буй арга хэрэгсэл хоцрогдсон, олон хэлбэрийг хослуулаагүйтэй холбоотой.

**График 13.** Та аймаг, сумын ЗД-ын талаар хэр мэдээлэлтэй байдаг вэ?



Судалгаанд хамрагдсан аймгуудын сум, аймгийн ЗДТГ-т мэдээлэл түгээх тогтсон уламжлал, горим гэхүйц зүйл ажиглагдахгүй байна. Иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын хувьд орон нутгийн засаг даргын үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан, дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжоор хангагдсан гэж үзэх үндэс бага байна (Жишээ 12.)

Жишээ 12. ...аймгийн засаг даргын үйл ажиллагаатай холбогдох нарийвчилсан, дэлгэрэнгүй мэдээллийг авъя гэвэл тийм амар өгөхгүй. Нэлээд чирэгдэл учруулж, залхаасаар байгаад өгөхгүй, эсвэл дутуу өгөх байх. Ялангуяа өөр намын хүн, байгууллага хандвал заавал хардаж сэрдэнэ

*(Булган аймаг, ИНБ-ын төлөөлөгчтэй хийсэн ярилцлагаас)*

Ер нь нутгийн удирдлагын бүх шатны субъектүүд мэдээлэлээ түгээхдээ гол төлөв хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, зурагт, сонин, хурал, яриа таниулгын ажил, мэдээллийн самбар ажиллуулах зэргээр түгээдэг байна. Хурал, яриа таниулгын ажил нь иргэдийн мэдээлэл олж авах гол хэрэгсэл болж байна. Ялангуяа сумын төвийн болон хөдөөгийн малчдын хувьд мэдээлэл авах гол хэрэгсэл болж өгдөг. Нутгийн удирдлагын эрх мэдэлтнүүдээс жилд, улиралд тодорхой давтамжтайгаар хурал, яриа таниулгын ажил зохион байгуулан, хэрэгжүүлсэн үйл ажиллагааныхаа талаар мэдээлэл дамжуулдаг нь социализмын үеэс тогтсон уламжлал юм.

Ихэнх аймгууд нь орон нутгийн сонин, телевиз, FM радиотой. Гэхдээ орон нутгийн ТВ, FM радиогоор дамжуулж буй мэдээллийг зөвхөн сум, аймгийн төвийн иргэд л хүлээн авах боломжтой. Орон нутгийн сонингууд төлбөртэй, харьцангуй цөөхөн дугаар гардаг нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл нутгийн удирдлагын байгууллагуудын мэдээллийг дамжуулах хүртээмжтэй мэдээллийн хэрэгсэл болж чадахгүй байна. Мөн орон нутгийн сонин, нутгийн удирдлагын байгууллага, хоорондын

харилцаа холбоо сул байна. Зах зээлд шилжсэнээр орон нутгийн сонингууд тогтвортой үйл ажиллагаагаа ажиллахад ихээхэн бэрхшээл учирч байна. Орон нутгийн сонингуудыг худалдан авдаг, захиалдаг иргэд харьцангуй цөөн, гол төлөв төрийн захиргааны албан хаагчид хүчээр захиалдаг байна. Учир нь иргэд өөрсдийнх амьдралд шууд хэрэгцээтэй мэдээллийг агуулаагүй сонинг захиалах нь бага байдаг. Гэхдээ иргэдийн зүгээс мэдээллээ түгээх талаар орон нутгийн удирдлагыг анхаарч ажиллахыг хүсч байна. (Жишээ 13.)

Жишээ 13. Мэдээллийн төрөл бүрийн сувагтай байх хэрэгтэй байна. ЗД-ын зүгээс юу хийх, ямар шийдвэр гаргах гэж буйгаа мэдээлмээр байна. Одоо багийн айл өрх бүр телевизтэй болсон тул үүнийг ашиглах хэрэгтэй.

(Хэнтий, Өмнөдэлгэр сумын иргэдтэй хийсэн бүлгийн ярилцлагаас)

Судалгаанд оролцсон иргэдийн 42,5 хувь нь «бусад хүмүүсийн ярианаас» нутгийн удирдлагын байгууллагуудын талаархи мэдээллийг олж авдаг гэж хариулжээ. Энэ нь нутгийн удирдлагын мэдээллийг олж авахад ам дамжсан яриа ихээхэн чухал болохыг харуулна. Нутгийн удирдлагын байгууллага бүр мэдээллийн самбар ажиллуулдаг. Гэхдээ мэдээллийн самбарын агуулга, өөрчлөлт, хаана байрладаг зэрэг нь иргэд мэдээлэл авахад нөлөөлж байгааг анхаарах хэрэгтэй.

Жишээ 14. Юуг яаж шийдсэн тухай бидэнд ямар ч мэдээлэл байдаггүй. Иймд иргэдэд зориулсан мэдээллийн төвийг нээн ажиллуулбал зүгээр.

(Булган аймгийн төв, эмэгтэйчүүдтэй хийсэн бүлгийн ярилцлагаас)

**Хүснэгт 7. Орон нутгийн удирдлагын талаархи мэдээллийг олж авдаг сувгууд**

	Тоо	Хувиар
Мэдээллийн самбар	87	22,4
Зурагт	143	36,9
Радио	50	12,9
Яриа таниулгын ажил	118	30,4
Хурал зохион байгуулах	153	39,4
Тараах хуудас	17	4,4
Веб хуудас	4	1,0
Бусад хүмүүсийн яриа	165	42,5
Авдаггүй	28	7,2

Мэдээлэл хүлээн авахад нэлээд үр өгөөжтэй хэрэгсэл болох тараах хуудаснаас мэдээлэл авсан иргэд 4,4 хувийг л эзэлж байна. Гэвч энэ нь зардал ихтэй тул төдийлөн оновчтой хэрэгсэл байж чадахгүй байна. Хөдөө орон нутагт дэд бүтэц, холбоо харилцаа хөгжөөгүйгээс орчин үеийн мэдээллийн гол хэрэгсэл болох веб хуудаснаас мэдээлэл авах байдал тун бага байна. «Цахим хөтөлбөр»-ийн хүрээнд аймгийн удирдлагууд веб хуудастай болох эхлэл тавигдсан хэдий ч тогтвортой ажиллахгүй

байгаагаас цаг үеийн мэдээллийг авах, өөрсдийн санаа бодлоо илэрхийлэх суваг болж чадахгүй хэвээр байна.

### 3.2. Иргэдтэй харилцах түвшин

Судалгаанд оролцогчдын 33.3 хувь нь сумын Засаг даргын шийдвэрт, 16.2 хувь нь аймгийн Засаг даргын шийдвэрт иргэдийн саналыг тусгадаг гэж хариулсан байна. (Хүснэгт 8) Энэ нь Засаг дарга нар мөрийн хөтөлбөртөө тусгасан хэдий ч шийдвэр гаргахдаа иргэдтэйгээ зөвлөлдөх байдал тааруухан байгааг харуулна. Гэхдээ тухайн шатны иргэдийн саналыг дамжуулагч, төлөөлөгч гол субъект болох ИТХ-аас арай илүүтэй байгаа бөгөөд иргэд ИТХ-тай харилцахаас илүү Засаг дарга нартай харилцдаг байна.

**Хүснэгт 8. Сум, аймгийн ЗД нар шийдвэр гаргахдаа иргэдийн саналыг тусгах байдал**


	Сумын ЗД	Аймгийн ЗД
Тусгадаг	33,3	16,2
Үгүй	27,8	29,9
Мэдэхгүй	38,9	53,9
Бүгд	100%	100%

Хаана оршин суугаа байршлын хувьд аймгийн ЗД-ын шийдвэрт нөлөөлдөг гэж хариулсан хүмүүсийн дийлэнхи нь аймгийн төвийнхөн, сумын ЗД-ын шийдвэрт нөлөөлдөг гэж үзсэн нь сумын төвийнхөн байлаа. Иргэдийн энэ байдалд орон зайн хүчин зүйл нөлөөтэй болохыг харуулж байна. Тодруулбал, хөдөө амьдардаг 20 хүний нэг нь л аймгийн ЗД-ын шийдвэрт иргэдийн санал тусгалаа олдог гэж үзжээ. Үүнээс 4 дахин их буюу аймгийн төв, сумын төвд амьдардаг 5 хүний нэг нь Аймгийн ЗД-ын шийдвэрт иргэдийн санал нөлөөлдөг гэж үзжээ. Эндээс хөдөөших тусам аймгийн түвшний шийдвэр иргэдээс алслагддаг, тухайн орон нутгийн удирдлага орон зайн хувьд хэр ойртоно төдий чинээ иргэн ба шийдвэр гаргагчдын хоорондын харилцааны зай ойртдог нь харагдаж байна.

Бүх шатны Засаг дарга төдийгүй орон нутгийн бүхий л удирдлагуудын хувьд иргэдийн санаа бодлыг сонсож, тэдэнтэй зөвлөлдөхдөө уулзалт ярилцлага зохион байгуулах, биечлэн уулзах, орон нутгийн мэдээлэл хэрэгслүүдийг орон нутгийн телевиз, сонин, радиог ашиглах, асуулга авах зэргийг илүүтэй ашиглаж байгаа бол веб хуудас буюу онлайн хэлбэрийг ашиглах явдал тун доогуур байна. (График 14.) Энэ нь хөдөө орон нутгийн дэд бүтцийн хөгжил, иргэдийн мэдээлэл технологийг хэрэглэх чадвар, дадал тааруухан байгаатай холбоотой. Иргэд бичгээр санал, асуулга авч иргэдийн саналыг цуглуулах нь илүү үр өгөөжтэй хэмээн үзэж байлаа. Түүнчлэн хөдөө орон нутагт техник технологийн саад бэрхшээлийн улмаас мэдээллийн хэрэгслүүдийг ашиглан санал авч, иргэдтэйгээ зөвлөлдөх нь хэрэгжиж чадахгүй байгаа ч цаашид энэ чиглэлд анхаарахыг цаг үе шаардах болжээ.




**График 14.** Иргэдийн санаа бодлыг асууж, зөвлөлдөх арга хэлбэрүүд



### 3.3. Иргэдэд тайлагнах байдал

Судалгаанд оролцогчдын 60,1 хувь нь сумын Засаг дарга, 41,7 хувь нь аймгийн Засаг дарга үйл ажиллагааныхаа тайланг тавьдаг гэж хариулжээ. Мөн л нутгийн удирдлагын бусад субъектүүдийн адилаар тайлангаа хэлэлцүүлэх байдал тогтмолжиж байнгын шинжтэй үйл ажиллагаа болоогүй нь 15-р графикаас харагдаж байна.

**График 15.** Сум, аймгийн ЗД нарын тайлангаа хэлэлцүүлдэг байдал, аймгаар



Шатлал буурах тусам үйл ажиллагааныхаа тайланг хэлэлцүүлдэг гэсэн хариулт иргэдийн дунд нийтлэг байна. Нутгийн захиргааны байгууллагын түвшин өгсөх тусам иргэд тэдгээрийн хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар мэдээлэлгүй, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нь чиглэсэн саналаа илэрхийлэх, хяналт тавих, үнэлэн дүгнэх боломж буурч байна.

Өмнө өгүүлж байсан асуудлын адил хөдөөших тусам аймгийн ЗД-ыг ажлаа тайлагнадаггүй (31,0%) гэж үзэх байдал нэмэгдэж байна. Энэ дүн судалгаа хийсэн 3 аймагт өөр өөр байна. Засаг дарга нарын ажлаа тайлагнах байдал аймгуудын хувьд харилцан адилгүй болохыг доорх график харуулж байна. Булганчуудын дийлэнхи нь сум, аймгийн засаг дарга нарын үйл ажиллагаагаа тайлагнадагийг мэдэж байхад Хэнтий, Архангайчуудын хувьд учир дутагдалтай байна.

Засаг дарга нарын ажлын тайлан, мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан зэргээс харахад тэд мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт, зохион байгуулсан арга хэмжээнүүдийнхээ талаар иргэдэд жилд 1 удаа тайлагнадаг болох нь харагдаж байв. Төсөв, түүний зарцуулалтыг тайлагнадаг гэж судалгаанд оролцогчдын хорь гаруй хувь нь үзжээ. (Хүснэгт 9.) Санхүү, эдийн засгийн яам, Зохистой хөгжил жөндөр төвийн хийсэн судалгаанаас төсвийн төлөвлөлтөд иргэний нийгмийн оролцоог хангаж байгаа өнөөгийн байдлыг судалсан байдаг. Судалгаанаас

**Хүснэгт 9. Нутгийн удирдлагын байгууллагууд юуны талаар тайлагнадаг вэ?**

	Тоо	Хувиар
Төлөвлөсөн үйл ажиллагааны талаар	135	34,8
Төсөв, түүний зарцуулалтыг	91	23,5
Төсөв, түүний тодотголыг	42	10,8
Зохион байгуулсан арга хэмжээнүүд	154	39,7
Тусламж дэмжлэгийн түгээлт	76	19,6
Мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт	199	51,3

үзэхэд төсөвтэй холбоотой мэдээллийн түгээлт, хүртээмж муу, хаалттай, нууцлаг байдаг нь төсвийн талаархи тааруухан ойлголттой байхад хүргэж улмаар төсвийн үйл явцад иргэдийн оролцоо хангагдахгүй байна гэж үзжээ. Энэхүү судалгаагаар төсвийн төлөвлөлтөд иргэдийн саналыг тусгадаггүй, хэрхэн зарцуулсан тухай тайлагнадаггүй болохыг тогтоожээ. (СЭЗЯ, ЗХЖТ, 2005, Төсвийн үйл явцад иргэний нийгмийн оролцоог хангах нь, хуудас-18).

Төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдлыг ханган, төр иргэдийн холбоог сайжруулах зорилтыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, утсыг ашиглан тулгамдсан асуудлаар иргэдтэй санал солилцож, тэдэнд хариулт өгдөг, иргэдийн санал хүсэлт, өргөдөлд тавьсан асуудлыг бодитойгоор хэрэгжүүлэн, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, төр иргэдийн холбоог бэхжүүлэх ажлыг өргөтгөнө гэсэн зорилтууд дэвшүүлж, энэ хүрээнд зарим ажлууд хийгдэж, иргэний нийгмийн төлөөллийг дэмжиж ажиллах болсон нь сайшаалтай. Сум, аймгийн ИТХ-тай харьцуулахад иргэд Засаг дарга нараа сайн мэддэг, тэдгээртэй холбогдож харилцах нь илүүтэй бөгөөд иргэдийн өргөдөл, гомдол, санал нь бичиг баримтын тодорхойлолт авах, тусламж дэмжлэг хүсэх зэрэг голдуу хувийн шинжтэй байдагтай холбоотой. Гэхдээ Засаг дарга нарын зүгээс иргэдтэй зөвшилцөх, үйл ажиллагаагаа тайлагнах, мэдээллээр хангах байдал хангалтгүй түвшинд байна. Иймд Засаг дарга нарын бодлого боловсруулалт, шийдвэр гаргалт, хэрэгжилтийн ил тод байдал харьцангуй хаалттай байна. Энэ нь материаллаг хүчин зүйлсээс хамаарч байгаагаас гадна шийдвэр гаргагчдын хувийн хандлага, ойлголтоос шалтгаалж байна.



## VII. ОРОН НУТАГ ДАХЬ ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУД

*Орон нутгийн шийдвэр гаргах цйл явцад зохион байгуулагдсан иргэд оролцох явдал нь ИНБ-ууд иргэдийг төлөөлж буй нэг механизм юм. Орон нутаг дахь иргэний нийгмийн байгууллагуудын чадавхи, цйл ажиллагааны хамрах хүрээ, санхүүгийн байдал сул байгаа нь шийдвэр гаргах цйл явцад оролцох, бцлгийн болон нийтийн эрх ашгийг нэгтгэж илэрхийлэх, хэрэгжүүлэхэд ихээхэн саад болж байна. Нэг талаас нутгийн удирдлага бодлогын цйл явцад ИНБ-ыг оролцуулах сонирхол, хандлага төлөвшөөгүй, нөгөө талаас ИНБ-ын зүгээс хүчтэй шаардлага тавьж оролцох арга замаа төдийлэн эрэлхийлдэггүй нь том тээг болж байна.*

Иргэдийн шийдвэр гаргах түвшин дэх оролцоог нэмэгдүүлэх, үр нөлөө бүхий оролцоог төлөвшүүлэхэд иргэний нийгмийн байгууллагуудын үүрэг чухал юм. Иргэний нийгмийн байгууллагууд нь иргэдийн эвлэлдэн нэгдэж эрх ашгийнхаа төлөө үйл ажиллагаа явуулах зохион байгуулалтын нэгэн хэлбэр болдог. Үүнд төрийн бус байгууллагууд (ТББ), иргэдийн хөдөлгөөн, сонирхлын янз бүрийн бүлгүүд зэргийг багтаан ойлгож болно.

Монгол улсад нийт 5000 гаруй ТББ бүртгэлтэй байгаагийн 10 хувь хөдөө орон нутагт, 90 хувь нь УБ хотод байрлалтай байна<sup>17</sup>. Нийслэл хоттой харьцуулахад хөдөө орон нутаг дахь ТББ-ууд тооны хувьд маш цөөхөн, санхүүгийн чадавхи сул, орон нутгийн удирдлагаас ихээхэн хамааралтай, байгууллагын хувьд бэхжээгүй, мэдээлэл авах боломж хязгаарлагдмал, үйл ажиллагаа нь тогтворжиж хэвшээгүй байгааг судлаачид онцлон дүгнэсэн байна<sup>18</sup>.

Судалгаанаас үзэхэд орон нутагт иргэдэд хүрч ажиллаж байгаа, тэдэнд танил болсон цөөн хэдэн иргэний нийгмийн байгууллагууд байна (Хүснэгт 10).

---

<sup>17</sup>Ардчиллын Боловсрол Төв. Монгол дахь ТББ-уудын дүр зураг. Судалгааны товч тайлан. 2006. Олон ургальч үзлийн төв сэтгүүл. 2006: 05

<sup>18</sup>Center for Citizens' Alliance. State of Civil Society in Mongolia. 2004-2005 Civil Society Index Report for Mongolia. Ulaanbaatar: 2006. p. 79, Г.Чулуунбаатар. Иргэний нийгэм, иргэдийн оролцоо, олон нийтийн хэвлэл мэдээллийн үүрэг. Монгол дахь ардчиллын хөгжил: сорилт, боломж. УБ: 2005



**Хүснэгт 10. Танай орон нутагт идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг ямар ТББ байдаг вэ?**

Шашны	0,51
Ядуурлыг бууруулах чиглэлийн	22,68
Төрийн байгууллагын хэрэгжүүлж буй төслүүд	0,25
Уламжлалт ТББ-ууд	13,65
Буруу нэрлэсэн	1,03
Олон байгууллагууд нэрлэсэн	22,16
Мэдэхгүй	37,88
Байхгүй	1,8
Нийт	100%

Орон нутгийн ТББ-уудыг ерөнхийд нь 4 ангилж болохоор дүр зураг харагдаж байна. Үүнд:

**Нэгдүгээрт:**

Уламжлалт ТББ-ууд буюу Монголд социалист нийгмийн үед залуучуудын, эмэгтэйчүүдийн, ахмадын, өсвөр үеийнхний гэх мэт чиглэлээр байгуулагдаж байсан бөгөөд 1990 оны ардчилсан хувьсгалын дараагаар нийгмийн шинэ орчинд шилжин өөрчлөгдсөн байгууллагууд байна. Тухайлбал, Монголын Ахмадын Холбоо, Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо, Монголын Залуучуудын Холбоо, Улаан Загалмайн Нийгэмлэг гэх мэт. Хэдийгээр шинэчлэгдэн хувьсаж байгаа боловч социалист нийгмийн үеийн уламжлалт бүтэц зохион байгуулалт, удирдлагын арга барил, мөн төртэй харилцах харилцаа нь тун бага өөрчлөгдөж байна. Хагас төрийн, хагас иргэний нийгмийн заримдаг шинжийг агуулж байгаа нь төсвөөс жил бүр хөрөнгө хуваарилдаг<sup>19</sup> орон нутгийн удирдлагад ажиллагсад ихэвчлэн удирдан ажилладаг<sup>20</sup>, төрийн байгууллагаас үүрэг даалгавар өгөх, түүнийгээ эргүүлэн тайлагнах явдал олонтаа байдаг зэргээс илт харагдаж байна.

**Хоёрдугаарт:**

1990-ээд оноос шинээр үүсэн байгуулагдсан байгууллагууд. Тухайлбал, Хуульч эмэгтэйчүүдийн холбоо, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн салбар, Нийгмийн дэвшил-эмэгтэйчүүд гэх мэт.

**Гуравдугаарт:**

Олон улсын байгууллагуудын төсөл хөтөлбөрийг үр дүнд эсхүл тухайн байгууллагын шууд дэмжлэгтэйгээр байгуулагдсан ТББ-ууд. Тухайлбал, Дэлхийн Зөн олон улсын төрийн бус байгууллагын сүлжээний байгууллагууд.

<sup>19</sup>Орон нутгийн Ахмадын хороо, Залуучуудын холбоо

<sup>20</sup>Орон нутгийн Эмэгтэйчүүдийн зөвлөлүүд, Улаан загалмайн нийгэмлэгүүд



**Дөрөвдүгээрт:**

Орон нутгийн иргэдийн үүсгэл санаачлагаар байгуулагдсан иргэдийн хөдөлгөөнүүд. Ихэвчлэн 2000 оноос хойш байгуулагдсан байна. Тухайлбал, Архангай аймаг дахь Ариун суварга хөдөлгөөн.

Судалгаанд оролцсон иргэдийн нас өгсөх тусам уламжлалт ТББ-уудын үйл ажиллагааны талаарх мэдээлэл ихсэх хандлага байна. (Хүснэгт 11.) Өөрөөр хэлбэл 18-35 нас иргэд уламжлалт ТББ-уудын тухайд төдийлэн мэдэхгүй байна. Харин бусад төрлийн байгууллагуудын хувьд 26-45 насныхан илүү их мэдээлэлтэй байна. Орон нутаг дахь ТББ-уудын талаарх мэдээлэл бүхий иргэдийн тоо хөдөө тийш болох тусам буурч байна. Зөвхөн уламжлалт ТББ-уудыг мэдэх түвшин сум, аймгийн төвтэй харьцуулахад хөдөөд бага зэрэг өндөр байна. Судалгаанд оролцсон нийт иргэдийн 60.2 хувь нь орон нутагт үйл ажиллагаа явуулдаг наад зах нь нэг ТББ-ыг нэрлэсэн байна.

**Хүснэгт 11. Уламжлалт ТББ-уудыг та мэдэх үү?**

Тухайн насны иргэдээс мэднэ гэж хариулсан хувь	
18-25	6,7
26-35	10,3
36-45	14,4
46-аас дээш	20,0

Иргэдийн хамгийн сайн мэдэж буй байгууллага бол ядуурлыг бууруулах чиглэлээр ажиллаж буй ТББ-ууд байна. Гэхдээ иргэд төдийлэн олон байгууллага нэрлэхгүй байна. Олонхи нь Дэлхийн Зөн байгууллагыг болон түүний салбар ТББ-уудыг нэрлэсэн байна. Олон байгууллага нэрлэсэн иргэдийн ихэнх нь мөн л Дэлхийн зөнг бичсэн байна. Олон иргэдийн хувьд Дэлхийн зөнг ТББ-ын сайн жишээ, иргэдэд хүрч юм хийж байгаа байгууллага хэмээн үнэлэх явдал нийтлэг байна.

Хэнтий аймагт ТББ-г нэрлэсэн иргэдийн 51.1 хувь ядуурлыг бууруулах чиглэлийн байгууллагууд гэснээс 90 гаруй хувь нь Дэлхийн Зөн, түүний сүлжээний байгууллагууд болох Хан Хэнтий Хамтын Хүч, Гэрэлт Ирээдүй төвийг онцолжээ.

**Хүснэгт 12. Төрийн бус байгууллагын талаар мэдэхгүй гэж хариулсныг аймгаар нь хувьчлан харуулбал**

Архангай	43,7
Булган	43,1
Хэнтий	26,9

Харин Архангай, Булган аймагт олон ТББ-ыг (ихэвчлэн 2-3) нэрлэсэн иргэдийн тоо харьцангуй их буюу 50 гаруй хувьтай байна. Гэтэл дээрх хоёр аймагт ямар ч ТББ-ын талаар мэдэхгүй гэж хариулсан иргэд Хэнтий аймагтай харьцуулахад хавьгүй олон байна. (Хүснэгт 12.)

Жишээ 15. Ард иргэд төрөөс илүү ТББ-тай ойр байдаг  
(Хэнтий, Батноров сумын иргэдтэй хийсэн ярилцлагаас)

Судалгаанаас үзэхэд орон нутгийн ТББ-уудын үйл ажиллагаа дараах чиглэлд илүү идэвхтэй байна. Үүнд:

- ❖ Ард иргэдэд тусламж дэмжлэг үзүүлэх-70.5
- ❖ Боловсрол, сургалт-46.2
- ❖ Ядуурал, ажилгүйдлийг бууруулах-40.5
- ❖ Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах-25.2
- ❖ Ард иргэдийн хамтын үйл ажиллагааг дэмжих-24.1
- ❖ Хүүхдийн эрхийг хамгаалах-24.1
- ❖ Байгаль хамгаалах-21.5

Орон нутагт байгаа ТББ-ууд ямар үйл ажиллагаа явуулж, түүнд нь иргэд хэрхэн оролцож байна вэ? Дээрх байдлаас дүгнэхэд орон нутгийн ТББ-ууд иргэдэд хэрэгцээтэй байгаа үйлчилгээг хүргэхэд түлхүү анхаарч, төрийн чиг үүрэг, ачааллыг хуваалцаж байна. Харин орон нутгийн шийдвэр гаргагчдад нөлөөлөх, тэдэнд хяналт тавих чиглэлд ТББ-ууд төдийлэн ажилладаггүй байна. (Жишээ 16.)

Жишээ 16. ИНБ-ууд мөнгө гуйхаа л мэддэг. Иргэдийг хөдөлгөж нөлөөлөх үүрэгтэй гэдгээ мэддэггүй, ухаардаггүй.

(Архангай аймгийн, ИТХ-ын төлөөлөгч)

Орон нутгийн иргэдийн 50 орчим хувь ТББ-уудын үйл ажиллагаанд оролцдог байна. (Хүснэгт 13). Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 6.4 хувь нь л иргэний хөдөлгөөний гишүүн байна. Иргэдийн 30 орчим хувь нь ТББ-уудаас зохион байгуулсан сургалтад хамрагдах болон тусламж дэмжлэг авч байсан нь оролцооны хамгийн түгээмэл хэлбэр байна. Мөн байгаль хамгаалах, эрүүл мэндийн чиглэлийн үйл ажиллагаанд нилээд оролцдог байна.

**Хүснэгт 13. Орон нутгийн ТББ-уудын үйл ажиллагаан дахь иргэдийн оролцоо**

Тогтмол	15,2
Хааяа	31,7
Огт үгүй	53,1

Судалгаанаас үзэхэд ТББ-ууд нь орон нутгийн иргэдийн адилаар шийдвэр гаргах үйл явцад төдийлэн оролцож чаддаггүй байна. Төрд хяналт тавьж, ард иргэдийн эрх ашиг, эрхийг хамгаалах чиглэлд идэвхтэй ажилладаг ТББ бараг алга байна гэж хэлж болохоор байна.

Төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд оролцож буй иргэдийн хувь боловсролын түвшин дээшлэх тусам ихсэх хандлага орон нутагт байна. Мөн төрийн байгууллагад ажиллагсад бусад салбарынхнаас илүүтэй оролцож буй хувьтай байна. Гэтэл хувийн сектор, ажилгүй иргэдийн оролцох хувь хэмжээ доогуур түвшинд байна.



**Хүснэгт 14. Орон нутгийн ТББ-уудын үйл ажиллагаан дахь иргэдийн оролцоо (огт оролцдоггүй иргэдийн эзлэх хувь, насны ангиллаар)**

18-25	70
26-35	46,6
36-45	56,7
46-аас дээш	47,8

Насны хувьд 18-25 насны иргэдийн 70.0 хувь нь орон нутгийн ТББ-ын үйл ажиллагаанд огт оролцдоггүй гэсэн байна. Бусад насны хувьд ерөнхийдөө ижил түвшинд боловч 26-45 насны иргэдийн оролцоо бага зэрэг илүүтэй байна (Хүснэгт 14).

Иргэдийн идэвхтэй, үр нөлөө бүхий оролцоо нь иргэдийн хоорондын итгэлцэл, хамтран ажиллах зан үйлээс хамаарч байдаг. Орон нутгийн иргэд орчны цэвэрлэгээ, байгаль хамгаалал, хоршоолол зэрэгт хамтран ажиллах байдал харьцангуй нийтлэг байна. (Хүснэгт 15.)

**Хүснэгт 15. Иргэдийн хамтран ажилладаг хэлбэрүүд**

Орчны цэвэрлэгээ	50,0
Байгаль хамгаалал	32,5
Ажлын байр бий болох, хоршоолол	20,9
Сонгуулийн сурталчилгаанд оролцох	22,5
Бэлчээр	23,2
Өвөлжилтэд бэлтгэх	17,5
Мад, эд хөрөнгөө хамгаалах	15,5

Орон нутгийн удирлагын Иргэний нийгмийн байгууллагуудын талаарх ерөнхий үнэлгээ, хандлага нилээд сөрөг буюу иргэний нийгмийн байгууллагуудын чадавхи сул, идэвхтэй тогтвортой үйл ажиллагаа бага хэмээн дүгнэх явдал нийтлэг байна. Нутгийн удирдлагын

хувьд уламжлалт гэгдэх Ахмадын, Эмэгтэйчүүдийн, Хөгжлийн Бэрхшээлтэй иргэдийн, Хүүхдийн байгууллагатай, сүүлийн жилүүд хүмүүнлэгийн чиглэлийн ТББ-уудтай зарим үйл ажиллагаа хамтран явуулах, арга хэмжээ зохион байгуулах хүрээнд л иргэний нийгэмтэй хамтран ажиллаж байна. Харин бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшинд иргэний нийгмийн байгууллагуудыг оролцуулах, санал солилцох, зөвлөлдөх явдал үндсэндээ үгүй байна. Төр иргэний нийгмийн байгууллагууд хамтран ажиллах, бодлого, шийдвэр боловсруулж гаргахад иргэний нийгмийн байгууллага үр нөлөөтэй оролцоонд саад болж буй олон хүчин зүйлс орон нутагт байна. Юуны өмнө хоёр талын харилцан итгэлцэл, хамтран ажиллах нийтлэг зарчим төлөвшөөгүй байна. Улс төр дэх намчирхал иргэний нийгэмд халдварлаж энэ нь эрүүл бус харилцааг бий болгож байна. Орон нутгийн удирдлагын иргэний нийгмийн талаарх хандлага, иргэний нийгмийн байгууллагуудын удирдлагын талаарх хандлага үнэлгээ ихээхэн зөрчилтэй байна.

Ер нь иргэд, иргэний нийгмийн байгууллагын хувьд орон нутгийн шийдвэр гаргах явцад идэвхтэй оролцох, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхэд нутгийн удирдлагын зүгээс янз бүрийн дарамт, ялгаварлал байгааг иргэд ч, ТББ-ууд ч олонтаа өгүүлж байгаа нь цаашид төр-иргэний үр нөлөө бүхий харилцаанд бэрхшээл үүсгэж болохыг анхаарах нь зүйтэй.

## VIII. ДҮГНЭЛТ

Орон нутгийн шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог хангах хэд хэдэн механизм байдгийг хууль, эрх зүйгээр зохицуулсан байдаг. Үүнд: орон нутгийн өөрөө удирдах байгууллагын анхны нэгж бол багийн иргэдийн нийтийн хурал юм. Иргэдийг төлөөлөн сонгогдсон сум, аймгийн ИТХ-ын төлөөлөгчдөөр дамжуулан өөрсдийн хүсэлт, санал бодлыг ИТХ-д оруулж болохоос гадна ИТХ-ын хуралдаанд оролцож болдог. Баг, сум, аймгийн Засаг дарга нарын мөрийн хөтөлбөрт иргэдийн эрх ашгийг тусгасан байдаг ба тэдэнд хандан иргэд өөрсдийн санал хүсэлтийг тавьж болдог. Мөн түүнчлэн орон нутгийн иргэний нийгмийн байгууллагуудаар дамжуулан иргэд санаа зовж буй асуудалд дуу хоолойгоо нэгтгэдэг. Хэдийгээр орон нутгийн шийдвэр гаргах, бодлого боловсруулах түвшинд иргэдийн үр дүнтэй оролцоог хангах дээрх механизмууд байдаг ч бодит амьдрал дээр үр дүнтэй хэрэгжихгүй байна. Ялангуяа сум, аймгийн ИТХ-ын шийдвэр гаргах үйл явц, сум, аймгийн Засаг даргын Тамгын газар, ИНБ-уудтай хамтарч ажиллах түвшинд иргэдийн оролцоо доогуур байгаа юм.

1. Тухайн багийн нийт иргэд шууд оролцож болох нутгийн өөрийн удирдлагын анхан шатны байгууллага болох ИНХ-д иргэдийн оролцооны түвшин бусад дээд шатны байгууллагатай харьцуулахад харьцангуй өндөр ч, маш доогуур үзүүлэлттэй байна. Судалгаанаас үзэхэд аймаг, сумын төвийн хувьд багийн ИНХ-ын ирц ихэнх тохиолдолд хангалтгүй, заримдаа ирц бүрддэггүй, тогтоосон хэмжээнд хүрдэггүй байна. Энэ нь хурлын хэлэлцэн шийдвэрлэх асуудлын хүрээ маш хязгаарлагдмал, холбогдох мэдээллийн хүртээмж муу байдгаас хамаарч байна. Иргэдэд нэгдэх, хамтран ажиллах сонирхол, сэдэл, хандлага төлөвшөөгүй, ИНХ-ын эрх мэдэл хязгаарлагдмал байгааг хүлээн зөвшөөрдөггүй, хурлаас гарах эцсийн үр дүн, холбогдох шийдвэрийг хардаггүй байна. Багийн ИНХ-ын хэв загвар, хэлэлцэх асуудал нь олон нийтийн оролцоог дэмжихэд чиглэгдэж чаддаггүй байна. ИНХ-ын дарга, тэргүүлэгчдийн иргэний нийгмийн талаарх мэдлэг тааруу, олон түмэнд хүрч ажиллах, мэдээлэлийн хүртээмж муу байгаа нь энэ нөхцөл байдлыг бий болоход нөлөөлж байна. Иргэдийн багийн ИНХ дахь оролцоо нь оршин буй нутаг дэвсгэр, нас, хүйсээс хамааралтай байна.



- ❖ Багийн ИНХ-ын эрх хэмжээ хязгаарлагдмал байгаа нь иргэдийн оролцоонд сөргөөр нөлөөлж байна. Иргэдийн багийн нийтийн хуралд оролцох идэвх, сонирхол муу байгаа нь юуны өмнө багийн хурлын эрх хэмжээ тун хязгаарлагдмал, баг өөрийн төсөв хөрөнгө санхүүгийн эрх мэдэл муутай, иргэдийн хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлууд нь дээд шатны байгууллагад уламжлагдах боловч ихэнхдээ тодорхой үр дүнгүй замхардагтай холбоотой байна.
  - ❖ Багийн ИНХ-ын талаархи иргэдийн мэдлэг боловсрол тааруу байгаа нь тэдгээрийн оролцоонд нөлөөлж байна. Иргэдийн дунд ИНХ-д оролцох ач холбогдол, зорилгыг зөвөөр ухаарсан зан үйл, ойлголт хандлага бий болоогүй цагт багийн ИНХ одоогийн байдлаасаа өөрчлөгдөх боломжгүй юм.
  - ❖ Багийн ИНХ-д оролцдоггүйн нэгэн чухалд шалтгаан бол мэдээлэлгүй байдал. Багийн иргэдэд чиглэсэн мэдээлэл түгээлт хязгаарлагдмал хүрээнд чиглэсэн, үр дүн муутай арга хэрэгслүүдийг ашиглах, ИНХ хэзээ болохыг мэдээгүй, ямар асуудал хэлэлцэх тухай мэдээлэл аваагүйгээс хуралдаа оролцож чаддаггүй байна.
2. Иргэдийн төлөөлөгчид нь сонгогчдынхоо санаа бодлыг гаргаж буй шийдвэртээ тусгах байдал туйлын хангалтгүй байна. Аймаг, сумын ИТХ-ын дэгд хуралдааны нээлттэй байдал тухайлбал, иргэд, ИНБ-уудын төлөөлөгчдийг хуралдаанд оролцуулах, хуралдаанаар хэлэлцэх асуудал, гаргасан шийдвэрийг олон түмэнд мэдээлэх талаар тусгаагүй байна. Зөвхөн сонгуулийн өмнө л сонгогдогч, иргэдийн хооронд багахан харилцаа үүсдэгийг эс тооцвол, ИТХ-ын төлөөлөгчид иргэдийн хооронд баттай харилцаа тогтоогүй байна. Иргэдийн мэдлэгийн түвшин, ИТХ-д оролцох тохиромжтой механизм байхгүй байгаа нь ийм нөхцөл бий болоход нөлөөлж байна. Дээрх бүх нөхцөл байдлууд иргэдийн оролцоонд сөргөөр нөлөөлж байна.
- ❖ Одоо хэрэгжиж буй хууль эрх зүйн болон инстутчилалын орчинд орон нутгийн шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн оролцоо маш хязгаарлагдмал байна. ИТХ-ын хуралдаанд иргэдийг оролцуулах, хурлаар хэлэлцэх асуудал, гаргаж буй шийдвэрүүдэд иргэдийн санал бодлыг тусгах талаар холбогдох журмуудад тусгах байдал учир дутагдалтай байна. Иргэдийн оролцоог дэмжих талаар хэд хэдэн дэвшилтэт санал санаачлагуудыг гаргасан байна. Жишээ нь: Булган аймаг иргэдийн оролцоог дэмжсэн нааштай санал санаачлагуудыг хэрэгжүүлж байгаагаас гадна зарим аймгуудын ИТХ-ын дэгд бусад байгууллагуудын төлөөлөгчдийг хуралдаанд оролцуулах, иргэдээс хуралд хэлэлцүүлэх асуудлыг санаачлан оруулж болно гэж заасан байна. Хэдийгээр ийм туршлага ховор байгаа ч иймэрхүү заалтуудыг хэрэгжүүлэх механизмыг бий болгоход

- ❖ улс төрийн намчирхал, иргэдийн хандлага саад болдог байна.
  - ❖ Орон нутгийн иргэдийн төлөөлөн болж сонгогдсон ИТХ-ын төлөөлөгчид нь, иргэдийн эрх ашиг, хэрэгцээ, саналыг судлан, бодлого шийдвэрт тусгах үүргээ биелүүлэхгүй байна. Төлөөлөгчид сонгогдсон тойргийнхоо иргэдийг төлөөлөх, иргэдтэйгээ хамтран ажиллахдаа тааруухан байна. Тэд сонгогчиддоо хийсэн ажлаа тайлагнадаггүй, сонгогчдын өмнө хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлдэг байна. Энэ нь орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад иргэдийн итгэх итгэл буурахад нөлөөлж байна. Орон нутгийн доод шатны удирдах байгууллагуудын бие даан ажиллах боломж бүрдээгүй, дээд шатныхаа байгууллагаас хараат байдалтай тогтолцоо байгаагаас иргэдийн итгэл буурах асуудал бий болдог байна.
  - ❖ Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын үйл ажиллагаанд оролцох оролцоог хангахад чиглэсэн одоогийн механизмуудын талаарх иргэдийн мэдлэг тааруу, иргэний боловсрол бага, орон нутаг, иргэдийн төлөөлөгчдийн үүрэг хариуцлага сул, иргэдийн оролцооны ач холбогдлыг үнэлж үзэхгүй байгаа зэрэг нь оролцооны механизмыг үр дүнтэй ашиглахад саад болж байна.
3. Сум, аймгийн ИТХ-тай харьцуулахад иргэд Засаг дарга нараа сайн мэддэг, Засаг дарга ч ажил үүргийнхээ дагуу иргэдтэй илүү харьцдаг. Гэвч Засаг дарга иргэдэд байнга тайлагнадаг байх мөн хийсэн ажлынхаа талаар хүмүүсээс санал бодлыг нь сонсдог байх талаар хууль эрх зүйн заалт, механизм байдаггүй байна. Судалгаанаас харахад иргэд Засаг дарга нарын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл авдаггүй, Засаг даргын үйл ажиллагааны нээлттэй байдал, эргэж тайлагнахыг хангалтгүй гэж үзсэн байна
4. Иргэдэд хүрч буй мэдээлэл нь ихэвчлэн болж өнгөрсөн үйл явдлын тухайд байхаас бус шийдэх гэж буй асуудлын талаарх зүйл байдаггүй. ИТХ болон Засаг даргын зүгээс иргэдийн дунд ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгуулах, холбогдох талуудыг хуралдаанд оролцуулж ярилцах зэрэг шууд оролцооны арга хэлбэрүүдийг хэрэгжүүлэхгүй байгаа нь асуудлыг шийдэх аргыг зөвхөн төр л мэддэг гэдэг хандлага удирдлагад байсаар байгаатай холбоотой байна. Ер нь нутгийн удирдлагын бүх шатны субъектүүд мэдээллээ түгээхдээ гол төлөв хэвлэл мэдээллийн хэрэгслүүд /ялангуяа зурагт, сонин/, хурал яриа таниулгын ажил, мэдээллийн самбар ажиллуулах зэргээр түгээдэг байна. Иргэдтэй зөвшилцөх, тайлагнах, тэдгээрийн мэдээллийг хангах арга барил, ашиглаж буй хэрэгсэл, сувгуудаа эргэн харж аль болох нийгмийн бүхий л бүлгийн гишүүдэд хүртээмжтэй байлгах үүднээс шинэ оновчтой хувилбаруудыг нэвтрүүлэн олон арга хувилбаруудыг хослуулан ашиглах нь чухал байна. Түүнчлэн хөдөө орон нутагт техник технологийн саад бэрхшээлийн улмаас

мэдээллийн хэрэгслүүдийг ашиглан санал авч, иргэдтэйгээ зөвлөлдөх нь хэрэгжиж чадахгүй байгаа ч цаашид энэ чиглэлд анхаарахыг цаг үе шаардах болжээ.

5. Орон нутаг дахь иргэний нийгмийн байгууллагуудын чадавхи, үйл ажиллаганы хамрах хүрээ, санхүүгийн байдал сул байгаа нь шийдвэр гаргах үйл явцад оролцох, бүлгийн болон нийтийн эрх ашгийг нэгтгэж илэрхийлэх, хэрэгцүүлэхэд ихээхэн саад болж байгаа ч нэг талаас нутгийн удирдлагад бодлогын үйл явцад ИНБ-ыг оролцуулах сонирхол, хандлага төлөвшөөгүй, нөгөө талаас ИНБ-ын зүгээс хүчтэй шаардлага тавьж оролцох арга замаа төдийлэн эрэлхийлдэггүй нь том тээг болж байна. Орон нутгийн удирдлага болон иргэдийн хувьд үйл ажиллагаанд нь илүүтэй хамрагдсан ИНБ-ууд нь ядуурлын эсрэг ажилладаг байгууллагууд ялангуяа Дэлхийн зөн, түүнтэй холбоотой орон нутгийн ТББ-ууд болон уламжлалт гэгдэх ахмадын, эмэгтэйчүүдийн байгууллагаар орон нутаг дахь ИНБ-ыг төлөөлж ойлгож байна. Орон нутгийн ТББ-ууд иргэдэд хэрэгцээтэй байгаа үйлчилгээг хүргэхэд түлхүү анхаарч, төрийн чиг үүрэг, ачааллыг хуваалцаж байгаа ч орон нутгийн шийдвэр гаргагчдад нөлөөлөх, тэдэнд хяналт тавих чиглэлд ТББ-ууд төдийлэн ажилладаггүй байна.
6. Өнөөгийн төрийн төвлөрсөн удирдлагын тогтолцоо нь нутгийн удирлагын хууль ёсны эрх хэмжээг олон талаар хязгаарлаж, нутгийн өөрөө удирдах ёсны зарчмыг алдагдуулж байгааг урьд хийгдсэн судалгааны дүн болон улс төрийн хэлэлцүүлгээс бид харж байна. УИХ-ын түвшинд энэ асуудал тавигдаж Үндсэн хуульд өөрчлөлт оруулах комисс байгуулагдсан. Цаашид төвлөрсөн удирдлагын тогтолцоо өөрчлөгдөж нутгийн удирдлагын эрх мэдэл нэмэгдэх тохиолдолд иргэний оролцооны асуудлыг орхигдуулж болохгүй юм.



## IX. ЗӨВЛӨМЖҮҮД

### БАГИЙН УДИРДЛАГАД

1. Багийн ИНХ дахь иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд ИНХ зохион байгуулж буй арга хэлбэр, мэдээлэл түгээлт, хэлэлцэх асуудлыг эргэн харах хэрэгтэй байна. Багийн ИНХ-ыг төрийн байгууллагуудын үйл ажиллагааны талаар мэдээлэл түгээх хэлбэрийг өөрчлөн, иргэдийн хамтаараа хэлэлцэж, хамтын шийдэлд хүрэх бодит хэлэлцүүлэг болгон зохион байгуулахад анхаарах.
2. Иргэдийн хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлуудыг дээд шатны байгууллагаар шийдвэрлүүлэх талаар санаачлагатай ажиллах, хэрхэн шийдвэрлэсэн талаар иргэдэд мэдээлэх.
3. Иргэдийнхээ иргэний боловсролыг нэмэгдүүлэх чиглэлээр хаярьяа нутгийн боловсролын байгууллага болон ИНБ-уудтай хамтран ажиллах, иргэдийн санаа бодлоороо нэгдэн нийлж, хамтран ажиллах явдлыг дэмжих, иргэдийн бүлэг, хамт олны үйл ажиллагаа, санаа бодолд тулгуурлан ажиллах.
4. Багийн бүхий л иргэдэд хүрэх мэдээллийн олон талт сувгуудыг эрэлхийлж нэвтрүүлэх, мэдээлэл түгээх тодорхой бүтэц, цагийн хуваарь бүхий болгож, мөрдөн ажиллах.
5. Багийн ИНХ-ыг нийгмийн бүлгүүдээр тухайлбал залуучуудын, ахмадуудын, эмэгтэйчүүдийн гэх мэт дэд хэсэгтэйгээр, мөн холимог бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулах.
6. Багийн удирдлага, бусад ажилтнууд улс төрийн боловсролоо ахиулах, иргэдтэй тулж санаачлагатай ажиллах

### СУМ, АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД

1. Аймаг, сумдын ИТХ-ын хуралдааны дэгүүдэд шийдвэр гаргах үйл явцад иргэд оролцох боломжийг тодотгон тусгах, ИТХ-ын хэлэлцэх асуудал, хурлаас гарсан шийдвэрийг ил тод болгох
  - а. ИТХ-ын тэргүүлэгчдийн шийдсэнээр биш, харин иргэдийн хүсэлтээр тэдгээрийн төлөөлөл ИТХ-ын хуралдаанд оролцохыг тусгах (ялангуяа Архангай аймаг),



- б. Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг сайтар бэлтгэх, судалгаа дүгнэлт гаргах, шийдвэрийн төслийг урьдчилан боловсруулж нийт иргэдээр хэлэлцүүлэх зорилгоор хуралдаанд бэлтгэх ажлын хэсгийг эсвэл хариуцан ажилладаг нэгжийг хурлын тэргүүлэгчдээс байгуулан ажиллах тухай тусгах. Ингэхдээ ажлын хэсэг буюу нэгжид иргэн, ИНБ-ын төлөөлөлийг багтаах тухай тусгах,
  - в. Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг болон иргэдийн оролцоотой гаргасан шийдвэрийг иргэдэд хэрхэн мэдээлэх талаар тодорхой тусгах,
  - г. Шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангах, гаргасан шийдвэр сурталчлах талаар ИТХ-ын төлөөлөгчдийн үүргээ биелүүлэх, төлөөлөгчдийн сонгогчидтойгоо ажиллах боломжийг сайжруулах үүднээс ИТХ-ын төсөвт тодорхой хөрөнгө зарцуулах тухай тусгах,
  - д. «Хуралдааны явцад гарсан санал, үзэл бодлын зөрүү, төлөөлөгчдийн ярианы нууцыг хуралдаанд оролцогчид бүрэн хадгалах үүрэгтэй» гэсэн дэгийн заалтыг хүчингүй болгох,
  - е. Иргэдийн төлөөлөгчийн хуралдаанд оролцож буй идэвхи, оролцоо, санал хураалтад оролцсон байдал зэргийн талаар иргэд мэдээлэл авах боломжийг дэгд тусгах,
  - ё. Иргэдийн саналыг зайлшгүй авсан байх ёстой эсвэл өргөтгөсөн хэлбэрээр зохион байгуулах асуудлуудын жагсаалтыг гарган дэгд тусгах,
2. Иргэдтэй зөвлөлдөх, санаа бодлыг нь сонсох, гарч буй шийдвэрт тэдний хэрэгцээ, санаа бодол туссан эсэхийг эргүүлэн тайлагнадаг зан үйлийг хэвшил болгож төрд үл итгэсэн олон нийтийн хандлагыг өөрчлөх (ялангуяа аймгийн ИТХ)
  3. Сонгогчид ба ИТХ хоорондоо ямар харилцаатай байх талаар ИТХ-ын төлөөлөгчдийн мэдлэгийг нэмэгдүүлэх, иргэдийн оролцооны механизм, сонгогдсон тойргийн хөгжил зэрэг сэдвүүдээр ур чадварын сургалтад хамруулах ИНБ-уудыг чадваржуулах, тэдний үйл ажиллагааг дэмжих, хамтарсан хурлуудыг зохион байгуулах, цаашид хэрхэн хамтран ажиллах талаар зарчмуудыг тохиролцох.
  4. ИНБ-уудаас гарсан санал санаачлагуудыг дэмжин гаргаж буй шийдвэртээ тусгах, гүйцэтгэлийг олон нийтээр хянуулах, мониторингийн системийг бий болгох. Төрийн зарим үйлчилгээнд мониторинг хийхдээ ТББ-уудтай хамтарч ажиллах.

#### АЙМАГ, СУМЫН ЗАСАГ ДАРГАД

1. ЗД нарын мөрийн хөтөлбөрт тусгагдсан иргэний оролцоог сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаануудыг тогтсон бодит үйл хэрэг болгох,

2. Сум, аймгийн засаг даргын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэлээр иргэдийг хангах, тэдэнтэй зөвлөлдөх, тайлагнах тогтмолжиж хэвшсэн бүтэц, удирдлагын арга барил, эрх зүйн босго шаардлагыг бүрдүүлэх,
3. Мэдээлэл түгээх 1-2 хэлбэр зонхилж байгааг халж төрөл бүрийн ялгаатай сувгуудыг ашиглах хэрэгтэй байна. Тухайн орон нутгийн нийгмийн бүхий л бүлгүүдэд (боловсрол багатай, ядуу, ажилгүйчүүд, хувиараа секторынхон, албан бус секторт хөдөлмөр эрхлэгчид, эмэгтэйчүүд, залуучууд, хөдөөгийн нүүдэлчин малчид зэрэг) мэдээлэл түгээх чиглэлээр анхаарч ажиллах.
4. ЗДТГ-ын ажилтнуудын улс төрийн боловсролыг ахиулах, иргэд олон нийттэй харилцах соёл, чадавхийг нэмэгдүүлэх

### **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД**

1. Орон нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуульд нутгийн удирдлагын байгууллага ялангуяа ИТХ-ын нээлттэй ил тод байдлыг шаардсан, иргэдийн үр нөлөө бүхий оролцоог дэмжсэн заалтуудыг нэмж оруулах
2. Нутгийн удирдлагад иргэдийн оролцоо нь орон нутгийн бие даасан байдлаас ихээхэн хамаарч байгаа нөхцөлд төвлөрлийг бууруулсан орон нутгийн бие даасан байдлыг дэмжсэн хуулийн өөрчлөлтийг холбогдох хуулиудад тусгах
3. Зарим асуудлаар тухайлбал газар, байгалийн баялаг зэргийн ашиглах, лизенз олгох гэх мэт зөвшөөрлийг нутгийн удирдлага бус, уугуул иргэд олгодог байх өөрчлөлтийг холбогдох хуулинд оруулах

### **ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУДАД**

1. Олон улсын иргэний нийгмийн хөтөлбөр, үндэсний төв байгууллагуудаас санал болгож буй нөөц боломжийг ашиглан байгууллага бэхжүүлэх, үйлчилгээгээ өргөжүүлэх талаар зорилготой, системтэй ажиллаж, орон нутгийн нөөц бололцоогоо ашиглан нөлөөлөлийн үйл ажиллагаа явуулах ур чадвартай болох,
